



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН



АУДИТЫН КОД: ГАГ-2019/20/-ГА-БНА/03/

**“БАЯНХОНГОР ЭРЧИМ ХҮЧ” ЦТХХК-ИЙН
2015-2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ҮР ДҮНД ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН
АУДИТЫН ТАЙЛАН**

Баянхонгор хот 2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Ахлах аудитор А.Цэням

Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Должмаа

Утас: 88119345 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

Аудитор: Ж.Өсөхбаяр

Утас: 99890393 Цахим хаяг: usukhbayer_j@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.

Цахим хуудас: www.audit.mn

		АГУУЛГА	
Тайланг хянасан: Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат Ахлах аудитор А.Цээням Тайланг бэлтгэсэн: Ахлах аудитор Б.Должмаа Аудитор Ж.Өсөхбаяр 2019 оны 06 дугаар сарын 20-ны өдөр Уг тайланг УАГ-ын Цахим хуудаснаас үзнэ үү: www.audit.mn Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70442424 дугаарын утас, 70442584 дугаарын факсаар харилцана уу. ХАЯГ: Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар Аймгийн ЗДТГ-ын байр, Баянхонгор сум, Баянхонгор аймаг-64000 Монгол Улс		Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	2
		Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	2
		Аудитын зорилт	2
		Аудитын хамарсан хүрээ	2
		Аудитын арга зүй	2
		Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт	2
		Аудитыг гүйцэтгэсэн хугацаа, аудитын багийн бүрэлдэхүүн	3
		Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдсан мэдээлэл, хэлэлцүүлсэн журам	3
		Аудит хийхэд гарсан хүндрэл, бэрхшээл	3
		Товчилсон үгийн тайлбар	3
		Үндсэн мэдээлэл	4
		АУДИТЫН ДҮН	6
		БҮЛЭГ 1.	6
		ЭХЗХ-НЫ ТОГТООЛООР БАТАЛСАН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ШААРДАГДАХ ХЭМЖЭЭНД 2015, 2017 ОНУУДАД ЗАРДЛЫГ БАГТААН ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.	6
		Орлогын төлөвлөгөөг 104.4-110.6 хувиар биелүүлж ажилласан боловч цахилгаан эрчим хүчний 2015-2017 онд үүссэн 14.9 сая төгрөгийн авлагыг барагдуулж ажиллаагүй байна.	13
		Батлагдсан төлөвлөгөөний дагуу хөрөнгийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулаагүй байна.	16
		БҮЛЭГ 2.	21
		Төлөвлөгөөнд худалдан авах хөрөнгийн нэр төрөл, тоо хэмжээ, төсөвт өртгийг тооцож тусгаагүй байна.	21
		ИЗТЗБАХ, хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны бус орлогоор санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ ТБОНӨХБАҮХАТухай хуулийг мөрдөөгүй байна.	22
		Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихдаа аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 43 тоот тогтоолоор баталсан журмыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	24
		БҮЛЭГ 3.	25
		Санхүүгийн үйл ажиллагаанд шинжилгээ хийж ажилласан боловч шинжилгээнд үндэслэн цаашид авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж ажиллаагүй байна.	25
		Тайланд онуудад хэрэгжүүлсэн ИЗТЗБАХ, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр өгөөжийг тооцож ажиллаагүй байна.	27
		Дэлхийн банкны МОН-3503 төслийн зээлээс 2012-2016 онуудад төлөх 182.7 сая төгрөгийг гэрээний дагуу төлөөгүй хугацаа хэтрүүлсэн байна.	28
		Гүйцэтгэх удирдлага нь 2016 онд аймгийн Засаг даргатай үр дүнгийн гэрээ байгуулаагүй, 2017 оны аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээг дүгнүүлж ажиллаагүй байна.	29
		Шалгагдагч байгууллагын санал:	31
		Саналд өгсөн тайлбар:	34
		АУДИТЫН ДҮГНЭЛТ	35
		АУДИТЫН ЗӨВЛӨМЖ	36

Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2019 оны А/03 тоот тушаалаар батлагдсан “Үндэсний аудитын газрын 2019 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн аудитын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн 2015-2017 оны үйл ажиллагааны үр дүнг шалгаж, аудитын дүн, дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулж, аймгийн ИТХ-д танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Орлого, зардлын төлөвлөлт, гүйцэтгэл оновчтой, үр дүнтэй эсэх?
2. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдал, түүнд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн үү?
3. Тайлант онуудын их засвар техник зохион байгуулалтын арга хэмжээг оновчтой, үр дүнтэй хэрэгжүүлсэн үү?

Аудитын хамарсан хүрээ

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн 2015-2017 оны санхүүгийн тайлан, үйл ажиллагааны төлөвлөгөө тайлан холбогдох бусад материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэв.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн болон гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС 3000-3100/, Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журам, арга зүйг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа болон судалгаа, санал асуулга авах, тайлан баримт материалд тулгуурлан харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэргээр аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Монгол Улсын үндсэн хууль
- Төсвийн тухай хууль
- Компанийн тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Шилэн дансны тухай хууль
- Аймаг, сумын ИТХ-ын хуралдааны тогтоолууд,
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт

**Аудитыг
гүйцэтгэсэн
хугацаа, аудитын
багийн
бүрэлдэхүүн**

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдаж, ахлах аудитор А.Цээням үе шатны ажлын чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Должмаа, аудитор Ж.Өсөхбаяр нар 2019 оны 05 дугаар сарын 13-ны өдрөөс эхэлж, 2019 оны 06 дугаар сарын 18-ний өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

**Аудитын
тайлангийн бүтэц,
түүнд тусгагдсан
мэдээлэл,
хэлэлцүүлсэн
журам**

Аудитын тайланг үндсэн мэдээлэл, аудитын дүн, аудитын дүгнэлт, зөвлөмж гэсэн агуулгаар бичлээ. Аудитын тайлангийн төслийг дарга, тэргүүлэх аудиторын зөвшөөрснөөр холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулан санал авч, тайлангийн эцсийн хувилбарыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулж, аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга, “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад хүргүүлэв.

**Аудит хийхэд
гарсан хүндрэл,
бэрхшээл**

Аудитын багаас шаардсан судалгааг тухай бүр үнэн зөв гаргаж, цаг хугацаанд ирүүлээгүй, мэдээллийг удаа дараа шаардуулсан нь аудит хийхэд хүндрэлтэй байв.

Товчилсон үгийн тайлбар

**ААНБ
АДБОУС
БНХАУ
БОШХ
ЗДТГ
ИЗТЗБАХ
ИТХ
МҮОНТ
ОНӨААН
ТБОНӨ
ТБОНӨХБАҮХАТХ
ТӨХК
ТУЗ
ҮАГ
ХАЦЭХ
ХК
ХҮТ
ХХК
ЦДАШ
ЦДАШС**

Аж ахуйн нэгж байгууллага
Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт
Бүгд найрамдах хятад ард улс
Борлуулалтын орлогод шаардагдах хэмжээ
Засаг даргын Тамгын газар
Их засвар техник зохион байгуулалтын арга хэмжээ
Иргэдийн төлөөлөгчийн хурал
Монголын үндэсний олон нийтийн телевиз
Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
Төрийн болон орон нутгийн өмч
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
Төрийн өмчит хувьцаат компани
Төлөөлөн удирдах зөвлөл
Үндэсний аудитын газар
Худалдан авах цахилгаан эрчим хүч
Хувьцаат компани
Хэрэглэгчдэд үйлчлэх төв
Хязгаарлагдмал хариуцлагатай компани
Цахилгаан дамжуулах агаарын шугам
Цахилгаан дамжуулах агаарын шугам сүлжээ

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1965 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 154 тоот тогтоолд аймгуудын эрчим хүчний газрыг 1965-1967 онд багтаан байгуулахаар заасны дагуу 1966 оны 04 дүгээр сарын 01-д Баянхонгор аймгийн төвд Эрчим хүчний үйлдвэр анх байгуулагдсан бөгөөд аймгийн ИТХ-ын 2002 оны 78 дугаар тогтоолоор 100 хувь орон нутгийн өмчит “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК болон өөрчлөгдөн зохион байгуулагджээ.

Тус компани нь 2015 оныг дуустал хүртэл “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК, 2016 оноос “Диспетчерийн үндэсний төв” ХХК- тай гэрээ байгуулан цахилгаан эрчим хүч худалдан авч ТУЗ, Захиргаа аж ахуй, Цахилгаан шугам сүлжээний шуурхай үйлчилгээний алба, Хэрэглэгчдэд үйлчлэх төв гэсэн үндсэн бүтэцтэйгээр Баянхонгор аймгийн төв болон 13 сумыг цахилгаан эрчим хүчээр хангаж байна.

Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний хүрээнд Баянхонгор аймгийн төв болон ойролцоох Өлзийт, Баян-Овоо, Эрдэнэцогт сумдыг 6кВ-ын 101.7 км, Шаргалжуут баг, Заг, Гурванбулаг, Жаргалант сумдыг 10 кВ-ын 144.4 км, Галуут, Баацагаан, Хүрээмарал, Баянбулаг сумдыг 15 кВ-ын 259.9 км, Бөмбөгөр, Бууцагаан, Заг сумдыг 35 кВ-ын 292 км ЦДАШ-аар тэжээж нийт 798 км ЦДАШ-аар 13 дэд станц трансформатораар дамжуулан цахилгаан түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагаа явуулж байна.

Эрчим хүчний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т заасны дагуу Эрчим хүчний зохицуулах хорооны 2010 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 23, 24 дүгээр тогтоолоор олгосон “Цахилгаан түгээх”, “Цахилгаанаар зохицуулалттай хангах”, Эрчим хүчний яамнаас 2013 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр олгосон “0.4-35 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт



тохируулга, дагалдах ажил үйлчилгээ”, Стандарт хэмжил зүйн газраас 2013 оны 06 дугаар сарын 11-ний өдөр олгосон “Загварын туршилтад тэнцэж, Монгол Улсад ашиглахыг зөвшөөрсөн цахилгаан соронзон хэмжлийн хэмжих хэрэгслийг засварлах, суурилуулах,

худалдах” тусгай зөвшөөрлийн дагуу цахилгаан түгээх, хангах үйл ажиллагааг явуулж байна. Дээрх үйл ажиллагааг 2017 оны байдлаар аймгийн төвийн болон 13 сумын 11305 хэрэглэгчдэд 83 орон тоотойгоор хүргэсэн бөгөөд 2014 онтой харьцуулахад ажиллагсдын тоо 6, хэрэглэгчийн тоо 707-оор нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Түгээлтэнд 2015 онд 33593.6 мян.кВтц цахилгаан авч 28997.9 мян.кВтц цахилгааныг хэрэглэгчдэд борлуулж байсан бол 2017 онд 31512.5 мян.кВтц цахилгаан борлуулж 2514.6 мян.кВтц-р 2015 оноос өссөн ч цахилгаан түгээлтийн алдагдал 15.8%-д хүрч 2.1%-иар нэмэгджээ.

Хүснэгт 1. Техник эдийн засгийн үзүүлэлтийн судалгаа /гүйцэтгэлээр/

ҮЗҮҮЛЭЛТ		Хэмжих нэгж	2015 он	2016 он	2017 он	Өөрчлөлт /2017-2015/
Түгээлтэнд авсан цахилгаан		мян.кВтц	33,593.6	35,396.7	37,414.2	3,820.6
Түгээлтэнд авсан цахилгааны дундаж тариф		төг/кВтц	54.2	55.0	111.2	57.1
Түгээлтэнд авсан цахилгааны нийт өртөг		сая.төг	1,819.8	1,945.8	4,161.2	2,341.4
Цахилгаан түгээлтийн алдагдал	Биет	мян.кВтц	4,595.7	4,678.1	5,901.7	1,306.0
	Хувь	%	13.7	13.2	15.8	2.1
Борлуулсан цахилгаан		мян.кВтц	28,997.9	30,718.6	31,512.5	2,514.6

Компанийн гүйцэтгэх захирлаар 2012 оны 12 дугаар сарын 18-ний өдрөөс М.Батбаяр, 2016 оны 07 дугаар сарын 25-ний өдрөөс Т.Отгонбаатар, ерөнхий нягтлан бодогчоор 1996 оноос 2016 оныг дуустал Н.Цэцэнчимэг, 2017.01.01-ний өдрөөс Б.Батбаатар томилогдон ажилласан бөгөөд эдийн засагчаар 2003 оноос хойш Ж.Уламбаяр нар ажилласан байна.

АУДИТЫН ДҮН

БҮЛЭГ 1.

Компанийн удирдлага нь өмч хөрөнгийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай захиран зарцуулах бодлого барьж ажиллаагүй байна.

ЭХЗХ-ны тогтоолоор баталсан борлуулалтын орлогын шаардагдах хэмжээнд 2015, 2017 онуудад зардлыг багтаан төлөвлөөгүй байна.

1. Эрчим хүчний зохицуулах хорооны /цаашид “ЭХЗХ” гэх/ 2005 оны 74, 2017 оны 06 тоот тогтоолоор баталсан “Хэрэглэгчийн эрчим хүчний тарифын саналыг хянах шалгах журам”-ын дагуу “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК үйл ажиллагааны төлөвлөгөөг өмнөх 3 жилийн орлого, зарлагын гүйцэтгэлд тулгуурлан төлөвлөн ЭХЗХ-оор хянуулж, хянагдсан төлөвлөгөөг доорх байдлаар төлөвлөн компанийн ТУЗ-өөр батлуулжээ.

Хүснэгт 2. Үйл ажиллагааны орлого, зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

сая.төг

Зардлын төрөл	2012 оны	2013 оны	2014 оны	2015 он		2016 он		2017 он	
	гүйцэтгэл	гүйцэтгэл	гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Борлуулалтын орлого	2,045.0	2,201.7	2,839.1	3,457.4	3,521.2	3,902.9	4,130.2	4,250.7	4,343.9
Бусад орлого	142.6	308.0	380.9	146.0	240.7	110.0	218.1	113.1	690.6
Түгээх үйлчилгээний орлого	-	-	-	-	-	-	-	1,957.7	1,957.7
НИЙТ ОРЛОГО	2,187.5	2,509.6	3,220.0	3,603.4	3,761.9	4,012.9	4,348.3	6,321.4	6,992.2
ХАЦЭХ-ний өртөг	1,142.9	1,183.6	1,660.6	1,930.0	1,819.8	1,904.6	1,945.8	4,039.3	4,161.3
Үйл ажиллагааны зардлын дүн	693.0	832.5	1,034.6	1,204.7	1,132.8	1,263.8	1,282.2	1,464.9	1,389.1
Элэгдлийн зардлын дүн	591.2	593.6	637.2	626.3	570.5	570.5	583.4	583.4	621.4
Орлогын албан татвараас бусад татварын дүн	7.4	6.9	8.3	12.5	9.4	9.5	9.8	10.6	11.2
Хөрөнгө оруулалтын өгөөжийн дүн	64.9	89.2	85.6	93.7	83.6	154.6	161.1	110.1	97.2
Үйл ажиллагааны бус зардал	91.2	199.5	220.9	146.0	167.0	110.0	137.0	103.0	309.9
НИЙТ ЗАРДАЛ	2,590.6	2,905.5	3,647.2	4,013.2	3,783.1	4,012.9	4,119.3	6,311.3	6,590.1
Татварын дараах ашиг алдагдал	(403.1)	(395.8)	(427.3)	(409.8)	(21.2)	-	229.0	10.1	402.1

Үндсэн үйл ажиллагааны орлогыг төлөвлөхдөө өмнөх 3 оны гүйцэтгэлд үндэслэн худалдан авах цахилгаан эрчим хүчний тооцоог гарган, Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4-¹д заасны дагуу Эрчим хүчний зохицуулах хорооноос баталсан хэрэглэгчдэд худалдах дараах тарифаар орлогыг төлөвлөж иржээ.

¹ Тариф тогтоох аргачлал боловсруулах, тарифын бүтэц тодорхойлох, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тарифыг хянаж батлах, хэрэглэгчдэд худалдах үнийг тогтоох, индексжүүлэлтийг хэрэгжүүлэх,

Хүснэгт 3 . Хэрэглэгчдэд худалдах ЦЭХ-ний үнэ тарифын өөрчлөлт

Мөрдсөн огноо		2014 онд мөрдсөн	2015 онд мөрдсөн	2016-2017 онд мөрдсөн
ЭХЗХ-ны тогтоолын дугаар	Хэмжих нэгж	2014.07.21-ний өдрийн №103	2014.11.19-ний өдрийн №192, №199	2015.07.06-ны өдрийн №199, 2015.07.10-ны өдрийн №212
Уул уурхайн үйлдвэр				
Уул уурхай /1 тариф/	төг/кВт.ц	135.00	151.60	155.90
Уул уурхай /3 тариф/				
Өдрийн /06.00-17.00/	төг/кВт.ц	135.00	151.60	155.90
Оройн /17.00-22.00/	төг/кВт.ц	239.00	271.70	276.00
Шөнийн /22.00-06.00/	төг/кВт.ц	65.00	72.80	77.10
Бусад ҮААНБ				
ААН/ 1 тариф /	төг/кВт.ц	110.60	124.20	128.50
ААН/ 3 тариф /				
Өдрийн /06.00-17.00/	төг/кВт.ц	110.60	124.20	128.50
Оройн /17.00-22.00/	төг/кВт.ц	183.00	205.50	209.80
Шөнийн /22.00-06.00/	төг/кВт.ц	65.00	72.80	77.10
Гэрэлтүүлэг / 2 тарифт /				
Өдрийн /06.00-19.00/	төг/кВт.ц	110.60	124.20	128.50
Шөнийн /19.00-06.00/	төг/кВт.ц	65.00	72.80	77.10
Айл өрх				
Энгийн тоолуур				
150 кВт.ц хүртэл хэрэглээ	төг/кВт.ц	64.00	94.10	98.40
151 кВт.ц-аас дээш хэрэглээ	төг/кВт.ц	101.60	113.90	118.20
2 тарифт тоолуур				
Өдрийн /06.00-21.00/	төг/кВт.ц	89.00	100.00	104.30
Шөнийн /21.00-06.00/	төг/кВт.ц	65.00	72.80	77.10
Задгай хэрэглээ				
кВт.цаг			350.00	350.00
Сарын суурь тариф				
төг/сар		1,000.00	1,000.00	2000.00
Эмзэг бүлгийн тариф				
50 кВт.ц хүртэл	төг/кВт.ц		43.90	48.20
51 кВт.ц-аас дээш	төг/кВт.ц		65.00	69.30

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн 2007-2016 онд хэрэглэгчдэд борлуулсан цахилгаан эрчим хүч, 2015-2017 оны борлуулах цахилгаан эрчим хүчний төлөвлөгөөг графикаар харуулбал:



Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф индексжүүлэх тухай” 2014 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 192 дугаар тогтоолоор хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тарифийг индексжүүлж баталсны дагуу 2015 оны үйл ажиллагааны орлогыг төлөвлөсөн бол “Тариф батлах тухай” 2015 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 199, 2015 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 212 дугаар тогтоолуудаар 2016, 2017 онуудын үйл ажиллагааны орлогыг төлөвлөжээ.

Хүснэгт 4. Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө

		2015 он	2016 он	2017 он
з		30474.0	29103.9	31371.3
ЦЭХ-ний орлого	сая.000	3457.4	3902.9	4250.7
Түгээх үйлчилгээний орлого	сая.000			1957.6
Түгээх ЦЭХ-ний дундаж тариф	000кВт.ц	113.5	134	135

Түгээх үйлчилгээний орлогыг 2017 оноос төлөвлөж эхэлсэн нь ЭХЗХ-ний 2014 оны 12 дугаар сарын 10-ний 231 тоот тогтоолоор баталсан “Цахилгаан, дулааны эрчим хүчний үнэ тарифыг тогтоох аргачлал”-ын дагуу борлуулалтын орлогоос төлөвлөсөн борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ /цаашид БОШХ гэх/-г компанийн үйл ажиллагаанд зарцуулж, үлдэх орлогыг худалдан авсан цахилгаан эрчим хүч /цаашид ХАЦЭХ гэх/-ний үнэнд тооцон “ЦДҮС” ТӨХК-д төвлөрүүлдэг байсныг 2017 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 04 тоот тогтоолоор тус аргачлалд нэмэлт өөрчлөлт оруулснаар борлуулалтын бүх орлогыг “ДҮТ” ХХК-д төвлөрүүлж компанийн төлөвлөгөөнд тусгагдсан БОШХ-г сар бүр түгээх үйлчилгээний орлого нэрээр буцаан олгодог болсонтой холбоотой байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогод цахилгаан эрчим хүчний үндсэн тарифаар тооцсон орлого, ЦЭХ-ний суурь хураамжаас гадна доорх хүснэгтэд дурдсан төлбөрүүд багтаж байгаа бөгөөд ЭХЗХ-ны “Тариф батлах тухай” 2015 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 199 дүгээр тогтоолоор чадлын төлбөр, 2015 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 212 дугаар тогтоолоор сэргээгдэх эрчим хүчийг дэмжих төлбөрийг шинээр баталж 2015 оны 08 дугаар сараас эхлэн дээрхи орлогуудыг төвлөрүүлж, 2016, 2017 оны орлогын төлөвлөгөөнд тусгажээ.

Хүснэгт 5. Шинээр мөрдөж эхэлсэн тариф

Мөрдсөн огноо	Хэмжих нэгж	2015.08.01-ий өдрөөс
Тогтоолын дугаар		2015.07.06-ны өдрийн №199, 2015.07.10-ны өдрийн №212
Чадлыг дэмжих төлбөр /Зөвхөн УААНБ/	төг/кВт/сар	9000
Сэргээгдэх эрчим хүчийг дэмжих төлбөр	төг/кВт.ц	4.0

ЭХЗХ-оос суурь тариф, сэргээгдэх эрчим хүчийг дэмжих төлбөр зэргийг нэмж тогтоосноор хэрэглэгчдэд борлуулж байгаа цахилгааны үнэ тариф сүүлийн жилүүдэд тогтмол өсч байгаа боловч эрчим хүчний үнэ өөрөө эдийн засгийн суурь үнэ болдог тул үнэ тарифыг зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг үндэслэх биш төрийн зохицуулалтаар буюу ЭХЗХ-оос тогтоож байгаа нь хэрэглэгчдийн худалдан авах чадвар, иргэд төрөөс үзүүлж буй эрчим хүчний үйлчилгээнд сэтгэл ханамжгүй байх нөхцөл болж байна.

Мөн аудитын явцад авсан санал асуулгаар эрчим хүчний төлбөр дээр хэрэглээтэй хамааралгүй сэргээгдэх эрчим хүчний төлбөрийг тарифаар тооцон авч байгаа нь хэрэглэсэн цахилгаан хэрэглээний төлбөрийг нэмэгдүүлж санхүүгийн дарамт үзүүлж байна гэсэн хариултуудыг иргэдээс өгч байгаа тул аймаг орон нутгийн удирдлагын түвшинд иргэдээс өгч байгаа саналыг холбогдох байгууллагуудад уламжилж ажиллах зөвлөмжийг аймгийн ИТХ-ын даргад хүргүүлэв.

2. Үндсэн бус үйл ажиллагааны орлогод багтах хүүгийн орлого, торгуулийн орлого, материал борлуулсны орлого, үйлчилгээний хөлс, МҮОНТ, хог тээврийн хураамж, тоолуур баталгаажуулсны орлогыг гэрээний үндсэн дээр хэрэглэгчээс хураасан үйлчилгээний хөлс, бусад байгууллагуудад гэрээгээр гүйцэтгэсэн ажлын орлого, бусад орлого зэргийг өмнөх онуудын гүйцэтгэл, хэрэглэгчийн өсөлтөд тулгуурлан тооцож төлөвлөсөн бөгөөд эдгээр орлогуудад алданги тооцдоггүй болно.

Хүснэгт 6. Үндсэн бус үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө

сая.төг

№	Орлогын төрөл	2015 он		2016 он		2017 он	
		дүн	эзлэх хувь	дүн	эзлэх хувь	дүн	эзлэх хувь
1	Хүүгийн орлого	3.2	2%	0	0%	5.0	4%
2	Торгуулийн орлого	15.0	10%	39.2	36%	35.0	31%
3	Материал борлуулсны орлого	18.0	12%	-	0%	-	0%
4	Үйлчилгээний хөлс	13.0	9%	13.3	12%	10.0	9%
5	Бусад байгууллагуудад гэрээгээр гүйцэтгэсэн ажлын орлого	37.3	26%	0	0%	0	0%
6	Бусад орлого	7.5	5%	0	0%	12.0	11%
7	Түрээсийн орлого	-	0%	0	0%	-	0%
8	МҮОНТ-ийн үйлчилгээний хөлс	20.0	14%	21.1	19%	22.0	19%
9	Хогны хураамжийн үйлчилгээний хөлс	32.0	22%	36.5	33%	25.1	22%
10	Тоолуур баталгааны орлого	-	0%	0	0%	4.0	4%
ДҮН		146.0	100%	110.0	100%	113.1	100%

Үндсэн бус үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөний бүтцээс харахад нийт орлогын 36.0-52.0 хувийг Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1²-д заасан телевизийн хураамж, Хог хаягдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1³-д заасан хогны хураамжийг тус байгууллагуудтай байгуулсан хамтран ажиллах гэрээний үндсэн дээр төвлөрүүлсэн үйлчилгээний хөлс эзэлж байна.

² 18.1.Олон нийтийн радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсийг нийтийн антенн, өөрийн сансрын хүлээн авах, нэвтрүүлэх станц, кабелийн телевизийн шугамтай эсэхээс үл хамааран айл өрхөд болон байгууллага, аж ахуйн нэгжид радио-хүлээн авагч, телевизор тус бүрээр тооцон ногдуулна.

³ 41.1.Энгийн хог хаягдал үүсгэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бүр хог хаягдлын үйлчилгээний хураамж төлнө.

Мөн торгуулийн орлогыг нийт орлогын 10-36 хувиар тооцож өмнөх онуудаас нэмэгдүүлж төлөвлөж байгаа нь хэрэглэгчдээс цахилгааны төлбөрийг хугацаанд нь төвлөрүүлж ажиллах гэсэн зарчимтай нийцэхгүй байна.

Харилцах дансны үлдэгдэлд тооцсон хүүгийн орлогоор 2014 онд 3.9 сая, 2015 онд 3.2 сая төгрөгийн орлого орсон байхад 2016 онд тус орлогыг төлөвлөөгүй нь орлогын боломжит эх үүсвэрийг бүрэн тооцоогүйтэй холбоотой байна.

3. Нийт зардлыг өмнөх 3 жилийн гүйцэтгэлд тулгуурлан төлөвлөсөн ба нийт зардлын 47.5-64.0 хувийг худалдан авах цахилгаан эрчим хүчний зардал эзэлж байна.

Хүснэгт 7. Нийт зардлын төлөвлөлт

Зардлын төрөл	2014 оны гүйцэтгэл	Төлөвлөгөө		
		2015	2016	2017
ХАЦЭХ-ний зардал	1,660.6	1,930.0	1,904.6	4,039.3
Үйл ажиллагааны зардал /БОШХ/	1,765.7	1,938.5	1,998.3	2,169.0
Үйл ажиллагааны бус зардал	220.9	146.0	110.0	103.0
НИЙТ ЗАРДАЛ	3,647.2	4,014.5	4,012.9	6,311.3

сая.төг

ХАЦЭХ-ний зардал:

Худалдан авах цахилгаан эрчим хүчний зардлыг ЭХЗХ-ны тогтоолоор баталсан тарифаар тооцож төлөвлөсөн байна.

Хүснэгт 8. ХАЦЭХ-ний зардлын төлөвлөгөө

□□□□□□	□□□□□ □□□□	2015 он	2016 он	2017 он
□□□□□□ □□□□□□	□□□□□□	36497.5	34647.5	36864.0
ХА□□□-□□□ зардал	сая.□□□	1930.0	1904.6	4039.3
ХА□□□-□□□ тариф	төг/кВт.ц	52.88	54.97	109.57

Хүснэгтээс харахад 2017 онд худалдан авах ЦЭХ-ний хэмжээг өмнөх оноос 2216.5 мян.кВт.ц-аар

нэмэгдүүлж тооцсон ч ХАЦЭХ-ний өртөг нь 2134.7 сая төгрөгөөр нэмэгдэж байгаа нь ЭХЗХ-ны 2017 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 04 тоот тогтоолоор “Цахилгаан, дулааны эрчим хүчний үнэ тарифыг тогтоох аргачлал”-д нэмэлт өөрчлөлт оруулан түгээх үйлчилгээний орлогыг эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд буцаан олгох болсонтой холбоотой байна.

Үйл ажиллагааны зардал:

ЭХЗХ-ны тогтоолоор баталсан борлуулалтыг орлогын шаардагдах хэмжээг компаний дүрмийн 8.2.1⁴-д заасны дагуу ТУЗ-өөр өөрчлөн баталж байгаа нь Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт, ЭХЗХ-ны 2005

⁴8.2 ТУЗ-өөс дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

8.2.1. Компанийн зорилтот түвшин, их засвар хөрөнгө оруулалтын төлөвлөгөө батлах

оны 74, 2017 оны 06 тоот тогтоолоор баталсан “Хэрэглэгчийн эрчим хүчний тарифийн саналыг хянах шалгах журам”-тай зөрчилдөж байгаа нь тус компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөг эцэслэн батлах субъект нь холбогдох эрх зүйн актуудын хувьд бүрэн зохицуулагдаагүй хоорондоо зөрчилдөж байгаатай холбоотой байна. Иймд тус компанийн үйл ажиллагааны онцлог, салбарын хууль тогтоомжуудтай нийцүүлэн компанийн дүрэмд өөрчлөлт оруулах зөвлөмжийг аймгийн ИТХ-ын даргад хүргүүлэв.

Үйл ажиллагааны төлөвлөгөөг ЭХЗХ-д хүргүүлж, хянагдсан төлөвлөгөөг ТУЗ-өөр баталдаг гэсэн тайлбарыг холбогдох албан тушаалтнууд өгч байгаа боловч тогтоолуудыг тулган шалгахад энэ нь батлагдахгүй байна. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт:

- Компанийн ТУЗ-ийн баталсан тогтоолыг ЭХЗХ-ны тогтоолтой харьцуулахад ТУЗ-өөс 2015 оны борлуулалтын орлогын шаардагдах хэмжээг 411.2 сая, 2017 оны борлуулалтын орлогын шаардагдах хэмжээг 170.6 сая төгрөгөөр илүү баталсан.

Хүснэгт 9. БОШХ-г ЭХЗХ-ны хянасан болон ТУЗ-өөр баталсан байдал

сая.төг

Зардлын төрөл	2015			2016			2017		
	ЭХЗХ-оос хянасан /2015.02.12/	ТУЗ-өөс баталсан /2015.01.19/	Зөрүү	ЭХЗХ-оос хянасан /2016.03.23/	ТУЗ-өөс баталсан /2016.02.03/	Зөрүү	ЭХЗХ-оос хянасан /2017.02.21 №76/	ТУЗ-өөс баталсан /2017.02.15/	Зөрүү
Цалингийн зардал	504	777.7	273.7	831.5	831.5	0.0	939.6	941.0	1.4
Элэгдлийн зардал	597.3	626.3	29.0	587.6	570.5	-17.1	587.6	583.4	-4.2
Бусад тогтмол зардал	426	534.5	108.5	579.2	596.2	17.0	471.1	644.5	173.4
НИЙТ ЗАРДАЛ	1527.3	1938.5	411.2	1998.3	1998.2	-0.1	1998.3	2168.9	170.6

- Компанийн ТУЗ-ийн 2015.01.19-ны өдрийн 02 тоот тогтоолоор 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан байхад ЭХЗХ-оос тусгай зөвшөөрлийн шаардлагыг тогтоосон тогтоолыг 2015.02.12-ны өдөр гаргасан, ТУЗ-ийн 2016.02.03-ний өдрийн 06 тоот тогтоолоор 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан байхад ЭХЗХ-ний тогтоол тус тогтоол гарсаны дараа буюу 2016.03.23-ны өдөр гарсан байна.

Нийт зардлыг өмнөх 3 жилийн гүйцэтгэлд тулгуурлан төлөвлөж байгаа ба



нийт зардлын 57.8-64.5 хувийг үйл ажиллагааны зардал эзэлж байна.

Үйл ажиллагааны зардлын төлөвлөлтөөс харахад зардлыг жил бүр нэмэгдүүлэн баталж байгаа ба зардлын төрлөөр авч үзвэл дараах шалтгаантай байна.

2015 он

Зардлын гүйцэтгэл 2014 онд 1772.5 сая төгрөг байсныг 166.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 1938.5 сая төгрөгөөр төлөвлөсөн боловч ЭХЗХ саналыг бууруулж 1527.3 сая төгрөгөөр баталжээ. Өмнөх оны гүйцэтгэлээс зардлыг нэмэгдүүлж баталсан нь цалингийн зардлыг ажилтан тус бүрт 50.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлснээс үндсэн цалин 45.9 сая, нэмэгдэл цалин 39.1 сая, сарын үр дүн 48.5 сая төгрөгөөр нэмэгдэж цалингийн зардал 133.5 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 13.1 сая, 2 тээврийн хэрэгсэл нэмэгдсэнтэй

холбоотой шатахууны зардлыг өмнөх оны гүйцэтгэлээс 3.4 сая, автомашинуудад засвар үйлчилгээ хийхээр төлөвлөснөөс сэлбэг хэрэгслийн зардлыг 7.0 сая, нөөцийн материалын нөхөн хангалтыг хийхээр материал хангамжийн зардлыг 4.2 сая, байгууллагын цахилгааны зардлыг худалдан авах цахилгааны тарифаар тооцдог байсныг ААНБ-д худалдах цахилгааны тарифаар тооцохоор болсноос цахилгаан, дулааны зардал 4.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж төлөвлөсөнтэй холбоотой байна.

2016 он

Өмнөх онд 1796.2 сая төгрөгийн зардалтай ажилласан бөгөөд 2016 оны зардлыг өмнөх оны гүйцэтгэлээс 202.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 1998.3 сая төгрөгөөр баталсан нь ажиллагсдад олгох жилийн үр дүнг 2 сараар олгож байсныг 2.75 сараар олгохоор төлөвлөснөөс 40.4 сая, сарын үр дүнг 20 хувиар олгож байсныг 23 хувь болгож нэмэгдүүлснээс 66.7 сая, цалингийн зардал нийт 107.1 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 10.7 сая, гүйцэтгэх удирдлагын зардал 9.0 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна. Мөн тус онд 3 ажилтан тэтгэвэрт гарахтай холбоотой ажиллагсдын нийгмийн зардал 71.0 сая, гишүүний тоо хоёроор нэмэгдсэнтэй холбоотой ТУЗ-ын зардал 2.2 сая, сэлбэг хэрэгслийн зардлыг 2.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

2017 он

Харин 2017 онд зардлыг 2141,4 сая төгрөгөөр баталсан нь өмнөх оны гүйцэтгэлээс 104.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Энэ нь тус онд техник үйлчилгээний инженер, гэрээний мэргэжилтэн, IT инженер, дотоод хяналт шалгалтын ажилтан зэрэг 4 орон тоо шинээр нэмэгдсэн, цалинг дунджаар 5 хувь нэмэгдүүлсэнтэй холбоотой цалингийн зардал 100.9 сая, гүйцэтгэх удирдлагын зардалд 8.3 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 10.4 сая, төлөвлөгөөт ажлын дагуу урсгал засварын зардал 4.1 сая, дотоод хэрэглээний цахилгааны тарифт сэргээгдэх эрчим хүч, чадлын төлбөр тооцсонтой холбоотой цахилгаан, дулааны зардал 6,0 сая, харуул хамгаалалтын гэрээний үнэ нэмэгдсэнтэй холбоотой 3,0 сая төгрөг, зөвлөх инженерийн цалингийн зардалд 3.0 сая төгрөг, шинээр орсон ажилтны хөдөлмөр хамгааллын хувцасны зардалд 4.3 сая төгрөг олгохоор тооцсон зэрэгтэй холбоотой байна. Мөн онд борлуулалтын албыг хэрэглэгчдэд үйлчлэх төвийн бүтцэд шилжүүлсэнтэй холбоотой ЦЭХ хэрэглэгчдэд мэдээлэл, сургалт хийх зорилгоор борлуулалт, маркетингийн зардлыг 3.0 сая төгрөг, мэргэшсэн инженер, төсөвчний сургалт төлөвлөсөнтэй холбоотой сургалтын зардал 4.1 сая төгрөг тус оны төсөвт нэмж баталсан бол шатахуун, сэлбэг хэрэгсэл, ажиллагсдын нийгмийн зардал, зээлийн хүүгийн зардлыг өмнөх оны гүйцэтгэлээс бууруулж төлөвлөжээ.

Үйл ажиллагааны бус зардал:

Үндсэн бус үйл ажиллагааны орлогоор 2015 онд 146.0 сая төгрөг оруулахаар төлөвлөснийг үйл ажиллагааны бус орлогоор хийгдэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан 10 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх зардалд, 2017 онд төлөвлөсөн 113.1 сая төгрөгийн орлогоос ХҮТ –ийн барилга худалдан авахад 100.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөжээ.

Харин 2016 онд үйл ажиллагааны бус орлогоос 110.0 сая төгрөгийг байгууллагын 50 жилийн ой угтсан арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Орлогын төлөвлөгөөг 104.4-110.6 хувиар биелүүлж ажилласан боловч цахилгаан эрчим хүчний 2015-2017 онд үүссэн 14.9 сая төгрөгийн авлагыг барагдуулж ажиллаагүй байна.

4. ЭХЗХ-оор хянагдаж компанийн ТУЗ-өөр батлагдсан орлогын төлөвлөгөөг аудитад хамрагдсан онуудад 104.4-110.6 хувиар биелүүлж ажилласан байна.

Хүснэгт 10. Үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

сая.төг

Орлогын төрөл	2015 он				2016 он				2017 он			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Борлуулалтын орлого	3,457.4	3,521.2	63.8	101.8	3,902.9	4,130.2	227.3	105.8	4,250.7	4,343.9	93.2	102.2
Бусад орлого	146.0	240.7	94.7	164.9	110.0	218.1	108.1	198.3	113.1	690.6	577.5	610.6
Түгээх үйлчилгээний орлого	-	-	-	-	-	-	-	-	1,957.7	1,957.7	-	100.0
НИЙТ ОРЛОГО	3,603.4	3,761.9	158.5	104.4	4,012.9	4,348.3	335.4	108.4	6,321.4	6,992.2	670.7	110.6
Борлуулах цахилгаан /мян.кВт.ц/	30474	28997.9	(1,476.1)	95.2	29103.9	30718.6	1,614.7	105.5	31371.3	31512.5	141.2	100.5

Хэрэглэгчдэд худалдах ЦЭХ-ийг 2015 онд 30474.0 мян.кВт.ц-аар төлөвлөсөн ч гүйцэтгэлээр 28997.9 мян.кВт.ц цахилгаан борлуулж 1476.1 мян.кВт.ц цахилгаан дутуу борлуулсан ч ЦЭХ-ний борлуулалтын орлогыг 63.8 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн нь тайлант жилийн дундуур ЭХЗХ-ны “Тариф батлах тухай” 2015 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 199 дүгээр тогтоолоор хэрэглэгчдэд худалдах тарифыг нэмэгдүүлснээс худалдах дундаж үнэ 11.6 төгрөгөөр өссөнтэй холбоотой байна. Мөн тус оны дундуур шинээр нэмэгдсэн чадлын төлбөрөөс 120.8 сая, сэргээгдэх эрчим хүчийг дэмжих төлбөрөөс 46.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Борлуулах цахилгааныг төлөвлөснөөс 2016 онд 1614.7 мян.кВт.ц, 2017 онд 141.2 мян.кВт.ц-аар давуулан борлуулж борлуулалтын орлого 2016 онд 105.8 хувь буюу 227.3 сая, 2017 онд 102.2 хувь буюу 93.2 сая төгрөгөөр давж биелжээ.

Үндсэн бус үйл ажиллагааны орлогыг он тус бүрээр нэр төрлөөр нь авч үзвэл:

Хүснэгт 11. Үндсэн бус үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө гүйцэтгэл

сая.төг

№	Орлогын төрөл	2015 он				2016 он				2017 он			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Хүүгийн орлого	3.2	3.2	0.0	0.0	0	11.1	11.1	0.0	5.0	13.7	8.7	273.7
2	Торгуулийн орлого	15.0	47.3	32.3	315.3	39.2	54.8	15.6	139.8	35.0	71.6	36.6	204.6
3	Материал борлуулсны орлого	18.0	16.3	(1.7)	0.0		16.2	16.2	0.0		27.3	27.3	0.0
4	Үйлчилгээний хөлс	13.0	5.5	(7.5)	42.5	13.3	33.4	20.1	251.7	10.0	32.9	22.9	329.4
	Бусад байгууллагуудад гэрээгээр												
5	гүйцэтгэсэн ажлын орлого	37.3	76.7	39.4	205.8	0	37.7	37.7	0.0	0	472.2	472.2	0.0
6	Бусад орлого	7.5	33.1	25.6	441.9	0	0.0	0.0	0.0	12.0	18.8	6.8	156.4
7	Түрээсийн орлого		0.1	0.1	0.0		0.0	0.0	0.0		-	-	0.0
8	МҮОНТ-ийн үйлчилгээний хөлс	20.0	21.8	1.8	109.0	21.1	22.4	1.3	106.2	22.0	16.0	(6.0)	72.9
9	Хогны хураамжийн үйлчилгээний хөлс	32.0	36.6	4.6	114.3	36.5	37.7	1.2	103.3	25.1	30.6	5.5	121.8
10	Тоолуур баталгааны орлого		-	-	0.0	0	4.8	4.8	0.0	4.0	7.5	3.5	187.2
	ДҮН	146.0	240.7	94.7	165%	110.0	218.1	108.1	198%	113.1	690.6	577.5	611%

МҮОНТ-ийн үйлчилгээний хөлснөөс орох орлого 2017 онд 6.0 сая төгрөгөөр тасарсан нь тус байгууллагатай байгуулсан хамтран ажиллах гэрээг 2017.04.10-ны өдөр шинэчлэн байгуулахдаа хураамжийн орлогоос үйлчилгээний хөлсөнд авах хувийг 10 хувиар бууруулан 15 хувь /өмнөх гэрээгээр 25%/ болгосонтой холбоотой байна.

Техникийн нөхцлийг компанийн ерөнхий инженер Барилгын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1⁵-д заасны дагуу ГХБХБГ-аас олгосон газрын зөвшөөрлийг үндэслэн олгож байгаа бөгөөд тухайн онд олгосон техникийн нөхцлийн судалгааг гаргадаггүй, орлогын тооцоог санхүүтэй нийлж баталгаажуулж хяналт тавиагүйгээс техникийн нөхцлийн орлого 5.9 сая төгрөгийг төвлөрүүлээгүй байна.

Аудитын илрүүлэлт:

Аудитын явцад 2015-2017 онд олгосон техникийн нөхцлийн судалгааг гаргуулахад нийт 153 иргэн, аж ахуйн нэгжид 15.7 сая төгрөгийн техникийн нөхцөл олгосон бөгөөд үүнээс 9.8 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж 5.9 сая төгрөгийг төлүүлээгүй ба компанийн зүгээс “2015-2017 онд техникийн нөхцөл авсан зарим иргэн аж, ахуйн нэгжийн маргаантай асуудлаас болж техникийн нөхцөл нь цуцлагдсан, зарим техникийн нөхцлийг ЭХЯ-аас олгосон байхад давхардуулан олгосон тул судалж төлүүлэх арга хэмжээ авч ажиллая” гэсэн тайлбарыг өгч байгаа тул 2019 оны 09 дүгээр сарын 01-ний дотор судалж төлүүлэх зөвлөмж өгөв.

5. Аудитад хамрагдсан онуудад авлага өссөн үзүүлэлттэй бөгөөд 2014 оны эцэст 84.8 сая төгрөгийн авлагатай байсан бол 2017 оны эцэст авлаг 461.8 сая төгрөг буюу 377.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 11. Авлагын үлдэгдэл

Авлагын төрөл	2014 он	2015 он	ЭЗЛЭХ ХУВЬ	2016 он	ЭЗЛЭХ ХУВЬ	2017 он	ЭЗЛЭХ ХУВЬ
ЦЭХ-ний авлага	42.5	80.6	60.7	51.5	46.5	78.9	17.1
Бусад авлага	42.3	52.1	39.3	59.2	53.5	382.9	82.9
Нийт	84.8	132.7	132.7	110.7	132.7	461.8	132.7

Тус онуудад нийт авлагын 17.1-60.7 хувийг цахилгаан эрчим хүчний авлага эзэлж байгаа бөгөөд хэрэглэгчдэд 2015 онд сард дунджаар 295.3 сая, 2016 онд 345.4 сая, 2017 онд 363.6 сая төгрөгийн ЦЭХ борлуулж борлуулалтын 98.1-99.0 хувийг цуглуулж ажилласан байна.

Хүснэгт 12. Авлагын цуглуулалт

Үзүүлэлт	2015 он	2016 он	2017 он
Тайлант оны ЦЭХ-ний бичилт	4,386.2	5,046.6	5,390.5
ЦЭХ-ний авлагын эхний үлдэгдэл	42.5	80.6	51.5
Орлого	4,345.5	5,073.8	5,363.9
Авлагын цуглуулалтын хувь	98.1%	99.0%	98.6%
ЦЭХ-ний авлагын үлдэгдэл	80.6	51.5	78.9

ЦЭХ-ний авлага 2015 онд өмнөх оноос 38.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тус онд

⁵ 22.1.Барилга байгууламжийн техникийн нөхцөл авах хүсэлтийг энэ хуулийн 22.2-т заасан инженерийн хангамжийн байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ. Хүсэлтэд дараахь баримт бичгийг хавсаргана:

22.1.1.эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөл;



ЦЭХ-ний 4386.2 сая төгрөгийн борлуулалт хийж 4345.5 сая төгрөгийг төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Авлагын үлдэгдлийг насжилтаар тооцож үзэхэд 2016 онд үүссэн нэг ААН-ийн 5.0 сая, 2017 онд үүссэн нэг ААН-ийн 6.6 сая төгрөгийн авлага барагдаагүйгээс 90-с дээш хоногтой авлагын дүн нэмэгдсэн байна.

Хүснэгт 13. ЦЭХ-ний авлагын үлдэгдэл насжилтаар сая.төг

№	Хугацаа	2015 он		2016 он		2017 он	
		Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь
1	0-30 хоног	64.5	80.0%	35.4	68.7%	53.5	67.8%
2	31-60 хоног	9.5	11.8%	6.5	12.6%	5.5	6.9%
3	61-90 хоног	5.5	6.8%	3.0	5.9%	5.1	6.4%
4	91-ээс дээш хоног	1.1	1.4%	6.6	12.7%	14.9	18.9%
Нийт		80.6	100%	51.5	100%	78.9	100%

Орон тооны авлагын мэргэжилтэн ажилласаар байхад өмнөх онуудад үүссэн гэр хорооллын 32 хэрэглэгчийн 2.0 сая, арилжааны 5 байгууллагын 12.9 сая нийт 14.9 сая төгрөгийн үлдэгдлийг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байгаа тул хэрэглэгчдээр авлагыг төлүүлэх албан шаардлага хүргүүлэв.

Бусад байгууллага, аж ахуйн нэгжээс 2017 оны эцэст 382.9 сая төгрөгийн авлагатай гарснаас 363.6 сая төгрөг нь 4 аж ахуйн нэгжтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулан гүйцэтгэсэнтэй холбоотой авлага бөгөөд дараа онд тус авлагыг бүрэн барагдуулсан ба 10.3 сая төгрөг нь аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэстэй автомашинтай холбоотой үүссэн авлага байна.

Авлагын эцсийн үлдэгдлээс сар бүр 0.01 хувиар найдваргүй авлагын нөөцийг байгуулж байгаа бөгөөд 2015 онд ТУЗ-ын шийдвэрээр “Алтан тулгуур” ХХК-тай холбоотой 3.4 сая төгрөгийн авлагыг найдваргүй авлагын нөөц сангаас хаасан байна.

Хүснэгт 14. Найдваргүй авлагын хасагдуулга данс

Үзүүлэлт	2015	2016	2017
Эхний үлдэгдэл	2,523,981.0	1,279,405.8	4,108,023.8
Дебет	3,441,447.2	-	-
Кредит	2,196,872.0	2,828,618.0	1,888,351.1
Эцсийн үлдэгдэл	1,279,405.8	4,108,023.8	5,996,374.9

Батлагдсан төлөвлөгөөний дагуу хөрөнгийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулаагүй байна.

6. ЭХЗХ-ны хянаснаар зардлыг төлөвлөж зарцуулаагүйгээс 2015-2017 онд 427.8 сая төгрөгөөр үйл ажиллагааны ашгийг нэмэгдүүлэх боломжийг алдсан байна.

Хүснэгт 15. Үйл ажиллагааны зардлын судалгаа

Зардлын төрөл	2015			2016			2017		
	ЭХЗХ-оос хянасан /2015.02.12/	ТУЗ-өөс баталсан /2015.01.19/	Гүйцэтгэл	ЭХЗХ-оос хянасан /2016.03.23/	ТУЗ-өөс баталсан /2016.02.03/	Гүйцэтгэл	ЭХЗХ-оос хянасан /2017.02.21 №76/	ТУЗ-өөс баталсан /2017.02.15/	Гүйцэтгэл
Цалингийн зардал	504	777.7	724.4	831.5	831.5	823.6	939.6	941.0	874.7
Элэгдлийн зардал	597.3	626.3	570.5	587.6	570.5	583.4	587.6	583.4	621.4
Бусад тогтмол зардал	426	534.5	501.4	579.2	596.2	629.6	471.1	644.5	622.8
НИЙТ ЗАРДАЛ	1527.3	1938.5	1796.3	1998.3	1998.2	2036.6	1998.3	2168.9	2118.9

Аудитын илрүүлэлт:

- ЭХЗХ-ны 2015 оны 46 дугаар тогтоолоор “Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК-ийн үйл ажиллагааны зардлыг 1527.3 сая төгрөгөөр тогтоосон ч ТУЗ-ын тогтоолоор 1938.5 сая төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 1796.3 сая төгрөг буюу 269.0 сая төгрөгөөр хэтрүүлсэн;
- ЭХЗХ-ны 2016 оны 82 дугаар тогтоол болон ТУЗ-ын тогтоолоор “Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК-ийн үйл ажиллагааны зардлыг 1998.3 сая төгрөгөөр тогтоосон ч гүйцэтгэлээр 2036.6 сая төгрөг зарцуулж 38.3 сая төгрөгөөр хэтрүүлсэн;
- ЭХЗХ-ны 2017 оны 94 дүгээр тогтоолоор “Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК-ийн үйл ажиллагааны зардлыг 1998.3 сая төгрөгөөр тогтоосон ч ТУЗ-ын тогтоолоор 2168.9 сая төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 2118.9 сая төгрөг зарцуулж 120.6 сая төгрөгөөр хэтрүүлсэн;


ТУЗ-өөс баталсан зардлыг 2015 онд 231.4 сая төгрөгөөр хэмнэсэн бол 2016 онд 106.5 сая, 2017 онд 278.8 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Үүнийг зардлын төрлөөр нь авч үзвэл цахилгаан эрчим хүчний хэрэглээнээс шалтгаалж худалдан авсан ЦЭХ-ний зардлыг 2015 онд 110.1 сая төгрөгөөр хэмнэж, 2016 онд 41.2 сая, 2017 онд 122.0 сая төгрөгөөр хэтэрсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Хүснэгт 16. Нийт зардлын төлөвлөлт

Зардлын төрөл	2014 оны гүйцэтгэл	2015		2016		2017	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
ХАЦЭХ-ний зардал	1660.6	1930.0	1819.8	1904.6	1945.8	4039.3	4161.3
Үйл ажиллагааны зардал /БОШХ/	1765.7	1938.5	1796.3	1998.3	2036.6	2169.0	2118.9
Үйл ажиллагааны бус зардал	220.9	146.0	167.0	110.0	137.0	103.0	309.9
НИЙТ ЗАРДАЛ	3,647.2	4,014.5	3,783.1	4,012.9	4,119.3	6,311.3	6,590.1
ХАЦЭХ /мян.кВт.цагаар/	33739	36,497.5	33,593.6	34,647.5	35,396.7	36864	37414.2

ХАЦЭХ-ний захиалгын гүйцэтгэл 2017 онд 101.5 хувьтай байгаа ч 2015 онд 92.0, 2016 онд 102.2 хувийн хэрэгжилттэй байгаа нь ЭХЗХ-оос баталсан цахилгаанаар зохицуулалттай

ГАГ-2019/20/-ГА-БНА/03/



хангах тусгай зөвшөөрлийн шаардлагын 2 дахь “цахилгаан эрчим хүчний хэрэглээний захиалгыг ± 2 хувиас хэтрэхгүй байх” гэсэн зорилтыг хангаагүй байна.

Үйл ажиллагааны зардлын төлөвлөгөө гүйцэтгэлээс харахад төлөвлөгөөг 2015 онд 73.2 сая, 2017 онд 75.7 сая төгрөгөөр хэмнэж, 2016 онд 18.4 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт:

ЭХЗХ-ны 15 жилийн ой, удирдах ажилтны зөвлөгөөнд оролцсон гүйцэтгэх удирдлагын зардал 4.9 сая, 2016 онд бороо ус, байгалийн хүчин зүйлээс болж Эрдэнэцогт, Шаргалжуут чиглэлийн ЦДАШ удаа дараа гэмтсэнээс урсгал засвар болон шатахууны зардал 10.4 сая, цахилгаан, дулааны ашиглалтын зардлыг ЭХЗХ төлөвлөснөөс 6.0 сая төгрөгөөр бууруулж баталснаас эдгээр зардал 7.8 сая төгрөгөөр хэтэрсэн нь 2016 оны үйл ажиллагааны зардал 18.4 сая төгрөгөөр хэтрэхэд голлон нөлөөлсөн байна.

Үйл ажиллагааны бус зардлыг 2015 онд 21.0 сая, 2016 онд 26.9 сая, 2017 онд 206.9 сая төгрөгөөр тус тус хэтрүүлсэн нь үйл ажиллагааны бус орлогыг 2015 онд 94.7 сая, 2016 онд 108.1 сая, 2017 онд 577.5 сая төгрөгөөр давуулан биелүүлсэнтэй холбоотой байна.

Ажиллагсад нийгмийн зардлыг гүйцэтгэлээр нь олгосон, хүүгийн зардлыг төлөвлөснөөс дутуу төлсөнтэй холбоотой хөрөнгө оруулалтын өгөөжөөр нөхөгдөх зардлыг 2015 онд 10.1 сая, 2017 онд 12.9 сая төгрөгөөр хэмнэсэн бол 2016 онд урт хугацаат зээлийн өмнөх онуудад төлөөгүй хүүгийн төлбөрт төлөвлөснөөс 23.2 сая төгрөгийг илүү төлснөөс зардлыг 6.5 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулжээ.

Үйл ажиллагааны бус зардлаас баяр ёслол, ой тэмдэглэх, хандив, тусламж, дэмжлэг үзүүлэх, тэмцээн уралдаанд хөрөнгө зарцуулахтай холбоотой гаргасан гүйцэтгэх захирлын шийдвэрүүдийг авч үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 17. Гүйцэтгэх захирлын бусад арга хэмжээнд хөрөнгө зарцуулахаар гаргасан шийдвэрүүд сая.төг

	Зардлын төрөл	2015	2016	2017
1	Шинэ жилийн арга хэмжээний зардал	1.1	2.8	6.3
2	Бусад баяр ёслол	1.4	45.6	-
3	Ажилчдыг аялал зугаалгаар явуулах зардал	9.5	2.4	5.0
4	Ажилчдын одон медалийн мөнгөн шагнал	1.8	4.2	6.0
5	Тэмцээн, уралдааны зардалд	3.5	2.8	23.7
6	Бусад байгууллага хувь хүнд өгсөн дэмжлэг	2.1	2.3	8.3
7	Зочид төлөөлөгчид хүлээн авах зардалд	0.7	-	3.7
	НИЙТ	20.1	60.0	53.1

Дээрх хүснэгтээс харахад тэмцээн, уралдаан, хандив тусламж, баяр ёслол, ой тэмдэглэх зэрэгт өмч хөрөнгийг өмнөх онуудын гүйцэтгэлээс нэмэгдүүлэн зарцуулж байгаа нь орон нутгийн өмчийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах бодлого барьж ажиллаагүйтэй холбоотой байна. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт:

• Гүйцэтгэх захирлын шийдвэрээр 2015-2017 онд бусад байгууллага, хувь хүнд 12.6 сая төгрөгийн хандив, тусламж, дэмжлэг олгосон нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10⁶ дахь заалтыг зөрчсөн.

• Компанийн 50 жилийн ойг угтаж хийж ажлын төлөвлөгөөнд батлагдсан 110.0 сая төгрөгөөс 53.6 сая төгрөгийг сургалтын полигон байгуулах, компанийн гаднах тохижилт, засварын ажил гэх мэт хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажилд зарцуулж 45.6 сая төгрөгөөр ойн тэмдэглэхтэй холбоотой зочид хүлээн авах, ном, сонин, танилцуулга гаргах, баяр наадам, тэмцээн уралдаанд зарцуулжээ.

• Аудитын явцад иргэдээс компанийн үзүүлж буй үйлчилгээнд сэтгэл ханамжтай байгаа эсэх талаар санал асуулга авсан ба санал асуулгад оролцогсдын 80 хувь нь сэтгэл ханамжгүй гэсэн хариултыг өгсөн байна. Компанийн ажиллах хүчний бүтцэд маркетингийн менежерийн орон тоо байхад 2017 онд “Баянхонгор бизнес мэдээллийн төв” НҮТББ-аар судалгааны ажлыг 3.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн нь ажиллах хүчний нөөц боломжийг бүрэн ашиглаагүй хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийг эрх бүхий этгээдээс гаргаагүй байхад 8.9 сая төгрөгийг зарцуулж, шийдвэрийг нөхөн гаргуулсан байна.

Аудитын илрүүлэлт:


• Эрчим хүчний системийн 95 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотод зохион байгуулагдах системийн аварга шалгаруулах тэмцээний зардалд 5.5 сая төгрөгийг 2017.09.28-д олгосон байхад тус хөрөнгийг зарцуулах ТУЗ-ийн шийдвэрийг 2017.12.01 өдөр нөхөн гаргасан.

• Найдваргүй авлагын нөөцийн сангаас “Алтан тулгуур” ХХК-ийн цахилгааны төлбөрийн үлдэгдэл 3.4 сая төгрөгийг 2015.12.31-д хаасан байхад ТУЗ-ын шийдвэр 2016.01.12-д гарсан байна. Энэ талаар тухайн үед ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байсан Н.Цэцэнчимээгээс тодруулахад “Алтан тулгуур ХХК нь манай үйл ажиллагаа явуулаагүй байхад танай трансформаторын хоосон явалтыг тооцож нөхөн бичилт хийсэн тул төлөх боломжгүй гэсэн тайлбар өгч төлөөгүй бөгөөд компанийн захирал нь нас барж 2010 онд шүүхэд хандах гэсэн боловч гэрээний хэрэгжилтийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан хариуцагч нас барсан тул нэхэмжлэл хүлээн авах боломжгүй гэсэн тул ТУЗ-өөр хэлэлцүүлж хаасан” гэсэн тайлбарыг өгсөн. Цаашид найдваргүй авлагын нөөц сангаас авлагыг хаахдаа хууль хяналтын байгууллагын шийдвэрийг үндэслэн ТУЗ-д асуудлыг тавьж шийдвэрлүүлж байх зөвлөмжийг компанийн гүйцэтгэх удирдлагад хүргүүлэв.

Аудитын явцад нэмэлтээр 2018-2019 оны компанийн бүтэц орон тооны судалгааг гаргуулан авч үзсэн бөгөөд 2015 онтой харьцуулахад 17 орон тоогоор нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Тухайлбал: дотоод аудитын ажилтан, гэрээний мэргэжилтэн,

тэнхимийн мэргэжилтэн, IT инженер, эрүүл мэнд биеийн тамир хариуцсан ажилтан, хэмнэлтийн инженер гэх мэт орон тоо шинээр нэмэгдсэн байна. Иймд

Бүтэц орон тооны төлөвлөгөө, гүйцэтгэл



⁶ 25.10.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно.

компанийн 2018-2019 оны орон тоо бүтцэд хяналт шалгалт хийх зөвлөмжийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэв.

7. Эрчим хүчний яам Монголын эрчим хүч, геологи уул, уурхайн үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын эрчим хүчний ассоциацийн хамтран байгуулсан “Эрчим хүчний салбарын хамтын хэлэлцээр”-ийн 3.3, “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн захиргаа, ҮЭ-ийн хооронд байгуулсан хамтын гэрээнд ажиллагсдын ажлын үр дүнг харгалзан жилийн үр дүнгийн урамшууллыг албан тушаалын тарифт цалингийн хэмжээгээр нь /жилийн үр дүнгийн шагналыг 5 сар хүртэл/ олгоно гэж заасны дагуу 2015 онд 2 сараар тооцож 78.2 сая, 2016 онд 3.5 сараар тооцож 120.3 сая, 2017 онд 3 сараар тооцож 120.7 сая төгрөгийн жилийн үр дүнгийн урамшууллыг олгосон байна.

Хүснэгт 18. Жилийн үр дүнгийн урамшууллын төлөвлөгөө гүйцэтгэл

сая.төг

Үзүүлэлт		2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он
Мөнгөн дүн	төлөвлөгөө	27.1	25.4	42.1	68.6	97.6	79.6	120.3	122.9
	гүйцэтгэл	27.1	25.4	34.6	67.1	74.4	78.2	120.3	120.7
Олгосон сар	төлөвлөгөө						2.0	2.75	2.75
	гүйцэтгэл	3.0	2.0	2.0	3.0	3.0	2.0	3.5	3.0

Гүйцэтгэх удирдлагын болон ажилчдын жилийн үр дүнгийн урамшууллыг эрх бүхий байгууллагын шийдвэр болон гэрээнд тусгагдсан хэмжээнээс нэмэгдүүлэн олгосон байна. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт:

- ТУЗ-ийн 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 02 тоот тогтоолоор ажилчдын 2016 оны жилийн эцсийн үр дүнгийн урамшууллыг 3 сарын цалинтай тэнцэх хэмжээгээр олгохоор баталсан ч гүйцэтгэх захирлын 2019 оны 02 дугаар сарын 15-ны 42 тоот тушаалаар 10 ажилтанд жилийн үр дүнгийн урамшууллыг 4 сарын цалинтай тэнцэх хэмжээгээр олгосон. Энэ талаар ТУЗ-ийн дарга С.Готовоос тодруулахад “нэг ажилтанд олгох жилийн үр дүнгийн урамшуулал нь 3 сарын цалинтэй тэнцэх хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр олгохоор шийдвэрлэсэн 4 сараар олгосон нь буруу” гэсэн тайлбарыг өгч байхад компанийн захирлын зөвлөлийн гишүүд нь “ТУЗ-аар жилийн үр дүнгийн урамшууллын хэмжээг батлуулахдаа 3 сарын цалингийн сантай тэнцэх хэмжээгээр ажилтнуудад олгуулахаар шийдвэр гаргуулж, тухайн баталсан санд багтаан олгохдоо хамтын гэрээнд заасныг үндэслэн ажлын гүйцэтгэлээр удирдлагын зөвлөлөөр шийдвэрлэн захирлын тушаалаар олгосон болно” гэсэн тайлбарыг хийж байгаагаас үзэхэд ТУЗ болон компанийн эрх бүхий ажилтнууд нь тус асуудал дээр ойлголтын зөрүүтэй байгааг харуулж байна.
- Компанийн гүйцэтгэх захирлаар Т.Отгонбаатар нь 2016 оны 07 дугаар сарын 20-ны өдөр томилогдсон ч аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулаагүй бөгөөд тус онд өмнөх захирал М.Батбаярын аймгийн Засаг даргатай 2016 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр байгуулсан гэрээг мөрдөж ажилласан гэсэн тайлбарыг өгсөн. Тус гэрээний 6.2-д гүйцэтгэх захирлын жилийн үр дүнг ТУЗ-ийн шийдвэрийг үндэслэн компанийн ажилчдад олгох хувийн дунджаар олгоно гэж заасан бөгөөд тухайн онд ажилчдад олгосон жилийн үр дүнгийн урамшууллын дундаж 2.7 сар байхад ТУЗ-ийн 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 02 тоот тогтоолоор гүйцэтгэх захирлын жилийн үр дүнг 4 сарын цалинтай тэнцэх хэмжээгээр олгохоор шийдвэрлэсэн.

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд ХҮТ-ийн байр худалдаан авахад 184.0 сая төгрөг ТУЗ-өөс баталж өгсний дагуу гүйцэтгэх захирлын 2017.03.21-ий өдрийн 56 тоот тушаалаар үнэлгээний хороо байгуулан худалдан авалтыг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулжээ. Тендерт иргэн А.Оюун, иргэн М.Алтантуяа болон ХАС банкны хамтран ирүүлсэн хоёр тендер оролцож 2011 онд ашиглалтанд орсон 153м² талбай бүхий үйлчилгээ оффисийн зориулалтай барилгыг 183.6 сая төгрөгөөр худалдах иргэн М.Алтантуяа болон ХАС банкны хамтран ирүүлсэн үнийн саналыг үнэлгээний хороо “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж үнэлэн гэрээ байгуулах эрх олгосны дагуу тус объектийг худалдан авсан байна. Харин иргэн А.Оюуны ирүүлсэн 1987 онд ашиглалтад орсон 45м² талбай бүхий орон сууцны барилгын 39.1 сая төгрөгийн үнийн санал нь тендерийн баримт бичигт тусгагдсан “110м² – аас доошгүй талбайтай байх” гэсэн шаардлагыг хангаагүй байна.

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн дүрмийн 10.2-д “Өмчлөгчийн хяналтыг хувь нийлүүлэгчдийн хурлаас томилогдсон Хяналтын зөвлөл хэрэгжүүлнэ” гэж заасан байхад Хяналтын зөвлөлийг байгуулаагүй байна.

Иймд компанийн хяналтын зөвлөлийг байгуулж, үр дүнг тооцож ажиллах зөвлөмжийг аймгийн ИТХ, компанийн ТУЗ-д хүргүүлэв.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн хуралдааны 62 тоот тогтоолоор компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн 7 хүний бүрэлдэхүүнтэй томилж, 2016 оны 10 дугаар сарын 28-ний өдрийн 102 тоот тогтоолоор 2 гишүүн нэмж 9 хүний бүрэлдэхүүнтэй болжээ. ТУЗ-ийн 9 гишүүний 7 гишүүн нь аймгийн ИТХ-ын төлөөлөгч, 2 хараат бус гишүүн байгаа нь Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4⁷-т заасантай нийцэхгүй байгаа тул хуульд нийцүүлэн ТУЗ-ийн гишүүдийг шинэчлэн томилох зөвлөмжийг аймгийн ИТХ-д хүргүүлэв.

8. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2015-2017 онд нийт 618.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Үүнээс 2015 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 85.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, 2016 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 440.7 сая, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 92.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, засвар шинэчлэлийн ажлууд хийгдснээр шугам сүлжээ, техник

⁷ Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна.

технологийн насжилтийг уртасгаж, аюулгүй ажиллагааг ханган, хэрэглэгчдэд чанартай, найдвартай цахилгаан эрчим хүчээр хангаж, сүүлийн үеийн техник, технологийг нэвтрүүлж хөрөнгө оруулалтын үр дүн гарсан байна.

Хүснэгт 19. Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн жагсаалт

сая.төг

№	Огноо	Хөрөнгийн ангилал	Хөрөнгийн нэр	Нийт дүн	Эх үүсвэр
1	10/9/2015	Барилга байгууламж	Цагаан хөтөл 6 кВ-н ЦДАШ	73.4	ОНХО-аар
2	12/1/2015	Барилга байгууламж	Эрдэнэцогт АТП-2	5.6	Эрдэнэцогт ОНХС
3	12/1/2015	Машин тоног төхөөрөмж	Трансформатор 250кВа Э/цогт 3064	6.5	Эрдэнэцогт ОНХС
2015 оны дүн				85.5	
1	12/1/2016	Барилга байгууламж	Галуут Мандалбаг 15 кВ ЦДАШ	378.4	улсын төсвийн хөрөнгөөр
2	12/1/2016	Барилга байгууламж	Галуут Мандал баг 04кВ ЦДАШ	44.3	улсын төсвийн хөрөнгөөр
3	12/1/2016	Барилга байгууламж	Галуут Мандал баг Дэд станц	18.0	улсын төсвийн хөрөнгөөр
4	12/1/2016	Барилга байгууламж	Бууцагаан Наран 5-р баг 35кВ ЦДАШ	26.0	Бууцагаан ОНХСан
5	12/1/2016	Барилга байгууламж	Бууцагаан Наран 5-р баг Дэдстанц	25.5	Бууцагаан ОНХСан
6	12/1/2016	Машин тоног төхөөрөмж	Наран 5-рбаг 35-100кВА трансформатор	13.5	Бууцагаан ОНХСан
7	12/1/2016	Машин тоног төхөөрөмж	Галуут Мандал 100кВ трансформатор	7.5	Галуут ОНХ Сан
8	12/5/2016	Барилга байгууламж	Бууцагаан Өлзийт баг Дэд станц	15.4	Бууцагаан ОНХСан
9	12/5/2016	Машин тоног төхөөрөмж	50кВА тр-тор Бууцагаан Өлзийт баг	4.1	Бууцагаан ОНХСан
2016 оны дүн				532.7	
НИЙТ ДҮН				618.2	

БҮЛЭГ 2.

ИЗТЗБАХ, хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны бус орлогоор санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ ТБОНӨХБАҮХАТухай хуулийг мөрдөж ажиллаагүй байна.

Төлөвлөгөөнд худалдан авах хөрөнгийн нэр төрөл, тоо хэмжээ, төсөвт өртгийг тооцож тусгаагүй байна.

9. Аудитад хамрагдсан онуудад 1417.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг улс, орон нутгийн төсөв, өөрийн хөрөнгө, хандив тусламжаар бэлтгэсэн байна.

Хүснэгт 20. Шинээр бэлтгэсэн үндсэн хөрөнгө

сая.төг

Үндсэн хөрөнгө	2015	2016	2017
Барилга байгууламж	157.2	570.1	259.3
Машин тоног төхөөрөмж	70.6	88.1	4.6
Тээврийн хэрэгсэл	19.0	110.3	13.9
Тавилга эд хогшил	24.2	28.5	71.3
Нийт дүн	271.0	797.0	349.1
Хөрөнгийн эх үүсвэр:			
Өөрийн хөрөнгөөр	180.6	262.2	349.1
Улсын төсвийн хөрөнгөөр		440.7	
Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	85.5	92.0	
Хандив тусламжаар	4.9	2.1	

Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд Галуут сумын Мандалын багийн цахилгаан шугам сүлжээний ажил 440.7 сая төгрөгөөр хийгдсэн бол орон нутгийн төсвийн хөрөнгөөр Эрдэнэцогт, Бууцагаан, Галуут сумдын дэд станц, шугам сүлжээний ажлыг шинээр хийж гүйцэтгэсэн байна.

Шинээр бэлтгэсэн нийт хөрөнгийн дийлэнх хувийг компани өөрийн хөрөнгөөр бэлтгэсэн бөгөөд төлөвлөлтийг хийхдээ холбогдох инженер техникийн ажилтнуудаас тооцоо судалгаа, хэрэгцээ шаардлагыг тодорхойлуулан төлөвлөгөөнд тусган бэлтгэж байна.

10. Харин эд хогшил худалдан авах зардалд 2015-2017 онд 70.0 сая төгрөгийг төлөвлөсөн ч худалдан авах хөрөнгийн нэр төрөл, тоо хэмжээ, худалдан авах үнийг тооцож батлуулаагүй байна.

ИЗТЗБАХ, хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны бус орлогоор санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ ТБОНӨХБАҮХАТухай хуулийг мөрдөөгүй байна.

11. ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1⁸-т заасны дагуу захиалагч компани нь үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгагдсан ИЗТЗБАХ-ний зардлаар болон урсгал засвар, үйл ажиллагааны бусад орлогоор хэрэгжүүлэхээр төлөвлөсөн Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор тогтоосон босго үнийн дээд хязгаараас дээш төсөвт өртөг бүхий 300.0 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн нь тус хуулийн 7 дугаар зүйлийн 7.1⁹ дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.1¹⁰ заалтыг тус тус зөрчсөн байна.

Хүснэгт . Худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй төсөл, арга хэмжээ

Арга хэмжээний нэр	2017		2016		2015	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Техник хэрэгсэл, эд хогшил худалдан авах	20.0	27.2	25.0	22.4	25.0	23.1
Программ хангамж хийлгэх, сервер худалдан авах	25.0	22.3				
Засвар үйлчилгээний ажлын зориулалтаар автокран худалдан авах			95.0	93.5		
Смарт тоолуур нэвтрүүлэхэд ТЭЗҮ боловсруулж зураг төсөв хийлгэх			10.0	0.0		
НББ-ийн бодлогын баримт бичиг хийлгэх	10.0	9.9				
Бөмбөгөр, Заг сумын диспетчерийн байрыг засварлах, Бууцагаан сумын байрыг өргөтгөх					15.0	2.0
Конторын барилгын их засвар			50.0	58.0		
Компанийн халаалтыг төвлөрсөн халаалтад холбох	25.0	26.5				
НИЙТ ДҮН	80.0	85.9	180.0	173.9	40.0	25.1

ИЗТЗБАХ, хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны бус орлогоор санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөж төлөвлөгөөнд тусгахдаа төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг зардал тус бүрээр гарган хэрэгжүүлэхэд шаардлагатай материалын хэмжээ, зардлыг тооцож, худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, материалыг ихэвчлэн БНХАУ-аас бэлтгэсэн байна. Иймд цаашид ИЗТЗБАХ,

⁸ 4.1.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;

⁹ 7.1.Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэчийг сонгож гэрээ байгуулна:

¹⁰ 47.1.Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг энэ хуулийн 8.1.1-д заасан дээд хязгаараас давсан тохиолдолд захиалагч үнэлгээний хороо байгуулна.

хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны бус орлого, урсгал засварын зардлаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг батлахдаа хэрэгцээ шаардлагыг бүрэн гүйцэт тодорхойлж, ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу худалдан авалтыг хийж хэрэгжүүлэн, хуулийн 49.2-т заасан материалаас бүрдсэн тендерийн хавтаст хэргийг бүрдүүлж ажиллах шаардлагатай байна.

Тус компанийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар худалдан авалтыг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу зохион байгуулах албан шаардлага өгсний дагуу 2018 оноос худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гаргаж ажиллажээ.

12. Аудитад хамрагдсан онуудад улс, орон нутгийн төсөв, болон өөрийн хөрөнгөөр шинээр бэлтгэсэн 1417.1 сая төгрөгийн хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4¹¹-т заасны дагуу санхүүгийн тайланд бүрэн тусгажээ.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит төсвийн байгууллага болон төсөвт үйлдвэрийн газар эд хөрөнгө олж авах, бүртгэх, дуудлагаар худалдах, шилжүүлэх, актлах журам”-ын 3.5¹²-д заасны дагуу 436.7 сая төгрөгийн хөрөнгийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар шийдвэр гаргуулан орлого авчээ. Тус журмын 3.4¹³-д заасны дагуу улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 440.7 сая төгрөгийн Галуут сумын Мандалын багийн ЦДАШ-ын ажлыг хөрөнгийн орлогод бүртгэсэн бол бусад эх үүсвэрүүдээр бэлтгэсэн хөрөнгийг орлого авахдаа ямар нэгэн шийдвэр гаргуулаагүй байна.

13. Орон нутгийн өмчийн 0.8 сая төгрөгийн хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр худалдаж, данснаас хассан байна.

Аудитын илрүүлэлт:

Аудитад хамрагдсан онуудад хөрөнгөд бүртгэлтэй 1998-2013 онд ашиглалтад орсон 33 нэр төрлийн 189.5 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлээс хасахдаа аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрийг үндэслэсэн байна. Харин 2013 онд ашиглалтад орсон 0.8 сая төгрөгийн үнэ бүхий зөөврийн компьютерийг 2016 онд данснаас хассан ч холбогдох шийдвэрийг гаргуулаагүй үлдэх өртөг болох 0.2 сая төгрөгөөр худалдсан байна. Иймд зөрчлийг дахин гаргахгүй байхад анхаарч ажиллах шаардлагатай байна.

¹¹ 13.4.Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.

¹² ТБОНӨ-т хуулийн этгээдэд улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын хандивлагч байгууллага, иргэд, хуулийн этгээдээс хэрэгжүүлсэн төсөл, зээл тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхэд үнэ, өртөг эзэмших хуулийн этгээд нь тодорхойгүй маргаантай тохиолдолд ОНӨА-д асуудлаа тавьж шийдвэрлүүлнэ.

¹³ Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд улсын төвлөрсөн төсвөөс хөрөнгө оруулалт хийж үндсэн хөрөнгө бэлтгэсэн тохиолдолд хөрөнгийн үнэ, өртөг, тоо хэмжээг тухайн хөрөнгийн санхүүжилтийг хийсэн ТЕЗ болон ТТЗ-ийн зөвшөөрлийг авч шууд данс бүртгэлдээ тусгана.

Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихдаа аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 43 тоот тогтоолоор баталсан журмыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

14. Аудитын явцад 2015-2017 онд шинээр бэлтгэсэн үндсэн хөрөнгүүдийн ашиглалтын байдлыг газар дээр нь шалгаж үзэхэд хөрөнгүүдийг зориулалтын дагуу ашиглаж байна. Өөрийн хөрөнгөөс 2015 онд Баацагаан сумын ашиглалтгүй барилгыг Төрийн банкинд түрээсээр ашиглуулан 70.9 мянган төгрөгийн түрээсийн орлогыг төвлөрүүлсэн бол 2016, 2017 онуудад өөрийн хөрөнгөөс бусдад эзэмшүүлж ашиглуулаагүй байна.

15. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2¹⁴, 70.2.1¹⁵, 70.2.2¹⁶ дахь заалтуудын дагуу эргэлтийн хөрөнгийн тооллогыг хагас бүтэн жилээр, үндсэн хөрөнгийн тооллогыг жилийн эцэст явуулж байгаа ч тооллогоор актлахаар шийдвэрлэсэн хөрөнгийг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэн данс бүртгэлээс хасаагүй, эргэлтийн хөрөнгийг акталж данснаас хасахдаа гүйцэтгэх захирлын шийдвэрийг гаргуулаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

- 2015 оны эд хөрөнгийн тооллого хийсэн тооллогын баримтыг ирүүлээгүй ба 2016 онд тооллогоор эд хөрөнгө, бараа материалын дутагдал гараагүй бөгөөд 3.1 сая /тооллогын тайланд 0.3 сая төгрөгөөр бичсэн/ төгрөгийн 12 үндсэн хөрөнгийг актлах саналыг аймгийн ИТХ-д явуулахаар шийдвэрлэсэн боловч холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй байна.
- Мөн 2016 оны жилийн эцсийн тооллогоор ашиглалтын хугацаа дууссан, эвдэрч хэмхэрсэн, цаашид ашиглах боломжгүй болсон 32 нэр төрлийн 5.4 сая төгрөгийн багаж хэрэгсэл, бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлсийг акталж, ашиглалтаас хасахдаа гүйцэтгэх захирал тушаал гаргаагүй байна.

Гүйцэтгэх захирлын 2016 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 106 тоот тушаалаар байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байхад тооллогын дүнг Захирлын зөвлөлд танилцуулсан нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 43 тоот тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит байгууллагуудын өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах нийтлэг журам”-ын 2.2¹⁷-т заасныг зөрчсөн байна.

Харин 2017 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын дүнг Өмч хамгаалах байнгын зөвлөлд танилцуулж, ашиглалтын шаардлага хангахгүй 37 нэр төрлийн 3.5 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийг данснаас хасах шийдвэрийг гаргуулжээ.

¹⁴ 2. Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана;

¹⁵ 1/ үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор/;

¹⁶ 2/ түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/;

¹⁷ Сум байгууллагын хагас жилийн болон жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын ажилд хяналт тавьж, дүгнэлт өгнө. Шаардлагатай гэж үзвэл хяналтын тооллого хийж болно

Эд хөрөнгийн тооллогын дүн, өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлтийг захирлын зөвлөлийн хуралд танилцуулж байгаа ч гүйцэтгэх захирлын тушаалаар баталгаажуулаагүй байгаа нь ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 43 тоот тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит байгууллагуудын өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах нийтлэг журам”-ын 2.10¹⁸-т заасныг зөрчсөн байна.

БҮЛЭГ 3.

Тайлант онуудын ИЗТЗБАХ, хөрөнгө оруулалтын ажлуудыг үр дүнтэй хэрэгжүүлснээр компани сүүлийн жилүүдэд ашигтай ажиллаж иржээ.

Санхүүгийн үйл ажиллагаанд шинжилгээ хийж ажилласан боловч шинжилгээнд үндэслэн цаашид авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж ажиллаагүй байна.

16. Компани нь 2010-2015 онуудад алдагдалтай ажиллаж байсан бол 2016 онд 228.9 сая, 2017 онд 402.1 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Үүнээс үндсэн үйл ажиллагааны борлуулалтын нэг төгрөгт ногдох зардлын хэмжээ 2016 онд 0.96 төгрөг, 2017 онд 0.99 төгрөг болсон байна.

Хүснэгт 22. Борлуулалтын 1 төгрөгт ногдох өртөгийн тооцоо төгрөгөөр

Өртөгийн төрөл	2015	2016	2017
Үндсэн үйл ажиллагааны өртөг	1.03	0.96	0.99
Үндсэн бус үйл ажиллагааны өртөг	0.69	0.62	0.45
Нийт борлуулалтын нэг төгрөгт ногдох өртөг	1.01	0.95	0.94

17. Үйл ажиллагааны ашиг 2016, 2017 онуудад нэмэгдэж борлуулалтын нэг төгрөгт ногдох өртөг нэмэгдэж байгаа нь ЭХЗХ-оос 2015 оны 07 сард хэрэглэгчдэд худалдах цахилгааны үнийг дунджаар 13 төг/кВт.ц-аар нэмэгдүүлсэн, цахилгаан эрчим хүчний хэрэглээ нэмэгдсэн, шугамын алдагдлыг өмнөх оноос 0.5 нэгжээр бууруулсан, 2017 онд цахилгаан эрчим хүчний хэрэглээ өмнөх оноос 2.1 сая/кВт.ц-аар өссөн, үйл ажиллагааны бус орлого 472.5 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 23. Үйл ажиллагааны ашиг алдагдал сая.төг

Орлогын төрөл	2014 он	2015 он	2016 он	2017 он
Үндсэн үйл ажиллагааны ашиг алдагдал	-206.3	-94.9	147.8	21.4
Үндсэн үйл ажиллагааны бус ашиг алдагдал	160	73.7	81.1	380.7
Нийт ашиг алдагдал	-206.3	-21.2	228.9	402.1

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2007 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдээс ногдол ашиг хуваарилах тухай” 166 тоот тогтоолын 1-т орон нутгийн өмч бүхий аж ахуйн нэгж, үйлдвэрийн газрын

¹⁸ Зөвлөлийн аливаа шийдвэр нь байгууллагын дарга, захирлын тушаалаар баталгаажна.


үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон цэвэр ашгийг хуваарилах нормативыг тогтоожээ. Тус нормативаар нийт ашгийн 45 хувийг үйлдвэрлэлээ өргөтгөхөд, 30 хувийг ажилчдын урамшуулалд, 25 хувийг орон нутгийн хөрөнгө оруулалтын санд хуваарилахаар тогтоосон байхад тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд дээрх тогтоолыг хэрэгжүүлж компаний үйл ажиллагааны үр дүнд бий болсон ашгийг оновчтой хуваарилах саналаа аймгийн ИТХ-д тавьж шийдвэрлүүлэх зөвлөмжийг компанийн ТУЗ-д хүргүүлэв.

18. “Баянхонгор-Эрчим хүч” ХХК-ийн цахилгаан түгээлтийн алдагдлыг ЭХЗХ-ний 2015 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 46 тоот тогтоолоор баталсан “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн цахилгаан түгээх тусгай шаардлагын 2.3-т Цахилгаан түгээлтийн алдагдлыг 2014 оны гүйцэтгэл (15.32%)-ээс бууруулах, 2016 оны 03 дугаар сарын 23-ний 82 тоот тогтоолоор цахилгаан түгээлтийн алдагдлыг 2016 оны зорилт (16.0%)-оос хэтрүүлэхгүй ажиллах, 2017 оны 03 дугаар сарын 28-ний 94 дүгээр тогтоолоор 14.9 хувиар тус тус тогтоосон байна.

Гэр хорооллын дэд станцуудыг хэрэглээтэй уялдуулан, шугам сүлжээний фазын ачааллыг тэнцвэржүүлэх, шинээр дэд станц барих, зүй бус хэрэглээг бууруулахад чиглэсэн тоолуурын лац, хайрцагны битүүмжлэлийг сайжруулсан зэргээс шалтгаалан 2014 онд 15.32 хувьтай байсан шугамын алдагдлыг 2015 онд 13.68 хувь, 2016 онд 13.22 хувь болгон бууруулжээ. Харин 2017 онд шугамын алдагдал 15.77 хувь болон нэмэгдснийг компанийн холбогдох албан тушаалтнууд “гүйцэтгэх захирлын шийдвэрээр ЦЭХ-ний бичилтийг 5 цикл болгон хуваан бичилт хийснээс хойших хэрэглэгчийн хэрэглээ дараа сард бичигдэж байгаатай холбоотой шугамын алдагдал өсөхөд нөлөөлсөн” гэсэн тайлбарыг өгсөн бөгөөд бодит шугамын алдагдал 13.9 хувьтай гарсан байна.

19. Борлуулалтын авлага цуглуулах дундаж хугацааны зохистой үзүүлэлт нь 10-15 хоног байдаг бол авлагын эргэцийн судалгаанаас харахад 2015 онд авлагыг дунджаар 14.6 хоногт цуглуулж байсан 2016 онд 15.2, 2017 онд 13.2 хоног болж буурсан сайн үзүүлэлттэй байгаа бөгөөд энэ нь сүүлийн жилүүдэд борлуулалтын орлого өссөнтэй холбоотой байна.



Компанийн 2015-2017 оны санхүүгийн тайланд шинжилгээ хийхэд нийт хөрөнгийн дунджаар 7.4 хувийг өр төлбөрөөр бүрдүүлж байгаа нь гадны эх үүсвэрээс хараат бусаар, өөрийн санхүүжилтээр бие даан үйл ажиллагаа явуулах чадвар сайн байгааг харуулж байна.

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа өндөр байгаа нь эргэлтийн хөрөнгөөр богино хугацаат өр төлбөрөө барагдуулах чадвар өндөр байгаа ч энэ нь бэлэн мөнгөний үлдэгдэл болон дансны авлагын үлдэгдэл өндөр байгаатай холбоотой байна.

Хүснэгт 24. Өр төлбөрийн харьцаа

Үзүүлэлт	2015	2016	2017
Бие даах чадварын коэффициент	92.17	92.65	93.04
Өр төлбөрийн хувийн жин	7.83	7.35	6.96
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	19.2	30.1	22.6

Тайланд онуудад хэрэгжүүлсэн ИЗТЗБАХ, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр өгөөжийг тооцож ажиллаагүй байна.

20. ИЗТЗБАХ-ий зардлаар 2015-2017 онд 2045.4 сая төгрөгийн 55 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр 1142.6 сая төгрөгийн 49 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж ажиллажээ.

Хүснэгт 25. ИЗТЗБАХ-ийн төлөвлөгөө гүйцэтгэл

Төсөл, арга хэмжээний зардлын төрөл	2015					2016					2017				
	Төл		Гүй		Зөрүү	Төл		Гүй		Зөрүү	Төл		Гүй		Зөрүү
	Тоо	Дүн	Тоо	Дүн		Тоо	Дүн	Тоо	Дүн		Тоо	Дүн	Тоо	Дүн	
Их засварын ажил	3	129.5	3	77.7	(51.8)	8	157.0	7	125.0	(32.0)	8	289.6	8	186.2	(103.4)
Техник зохион байгуулалтын арга хэмжээний зардал	5	30.7	5	14.3	(16.4)	3	23.0	2	9.8	(13.2)	5	36.7	4	27.6	(9.1)
Хөрөнгө оруулалтын ажил	4	235.0	3	63.5	(171.5)	6	205.0	6	211.9	6.9	13	938.8	11	426.6	(512.2)
НИЙТ ЗАРДЛЫН ДҮН	12	395.2	11	155.5	(239.7)	17	385.0	15	346.7	(38.3)	26	1,265.1	23	640.4	(624.7)
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаар		215.2		155.5			385.0		346.7			825.1			
Бусад эх үүсвэрээр /аймаг, сумдын хөрөнгөөр/		180.0										440.0			

2015 онд орон нутгийн төсвийн эх үүсвэр шийдэгдээгүйгээс 100.0 сая төгрөгийн Шаргалжуут тосгоны 04 шугам, дэд станцын өргөтгөл шинэчлэлийн ажил хэрэгжээгүй, 2016 онд 8.0 сая төгрөгийн 4 машины автогражийн засвар дулаалгын ажил, 10.0 сая төгрөгийн аймгийн төвийн 6кВ-ын ЦДАШ болон дэд станц, смарт тоолуурын ТЭЗҮ боловсруулах ажил тус тус хэрэгжээгүй, 2017 онд 3.4 сая төгрөгийн агаарын шугмыг 2 талын тэжээлтэй болгох ажил, 9.5 сая төгрөгийн нөөцийн трансформатор худалдан авах ажил, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө шийдэгдээгүйгээс 250.0 сая төгрөгийн аваарын дизель генератор худалдан авах ажил хэрэгжээгүй, нийт 2015-2017 онд 380.9 сая төгрөгийн 6 арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Бусад хэмнэлт нь арга хэмжээний төсвийг төлөвлөхдөө ажиллах хүчний зардлыг оруулан тооцсон ч гүйцэтгэлээр зөвхөн материалын зардлаар гүйцэтгэсэнтэй холбоотой байна.

ЭХЗХ-ноос тогтоосон цахилгаан түгээх тусгай зөвшөөрлийн шаардлагад ТЗБАХ, хөрөнгө оруулалтын ажлуудыг бодитой төлөвлөж бүрэн хийж гүйцэтгэх, үр өгөөжийг эдийн засгийн үнэлгээний аргачлалын дагуу тооцох гэсэн заалт байгаа ч тус аргачлалын дагуу үр өгөөжийг тооцоогүй, 2015-2017 онд төлөвлөсөн 6 арга хэмжээг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

21. УИХ-ын тогтоолын 2010 оны 72 дугаар тогтоолын хүрээнд Сангийн яам болон Баянхонгор-Эрчим хүч ЦТХХК-ийн хооронд байгуулсан 3503-МОГ дугаартай дамжуулан зээлдүүлэх гэрээгээр хэрэгжүүлсэн гэр хорооллын 0.4кВт-ын ЦДАШ-ын шинэчлэл, дэд өртөөний өргөтгөл шинэчлэлийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

Сангийн яам, Баянхонгор аймгийн ЗДТГ-ын хооронд “Орон сууцны санхүүжилтийн төсөл”-ийн Б бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 2006 оны 04 сарын 19-ний өдөр байгуулсан гэрээгээр авсан зээлийг хэрэгжүүлснээр Баянхонгор сумын 1 дүгээр багийн Шинэ төгөл амины орон сууцны хороололд шинээр ЦДАШС-ийн ажил хийгдэж 60 орчим айлыг цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангасан байна.

Дэлхийн банкны МОН-3503 төслийн зээлээс 2012-2016 онуудад төлөх 182.7 сая төгрөгийг гэрээний дагуу төлөөгүй хугацаа хэтрүүлсэн байна.

22. Дээрх урт хугацаат зээлүүдийн төлөлтийг зээлийн эргэн төлөлтийн хуваарьтай тулгахад Азийн хөгжлийн банкны МОН-1847 төслийн зээлийг гэрээний дагуу төлсөн харин Дэлхийн банкны МОН-3503 төслийн зээлээс 2012-2016 онуудад төлөх 182.7 сая төгрөгийг гэрээний дагуу төлөөгүй хугацаа хэтрүүлсэн байна.

Хүснэгт 26. Урт хугацаат зээлийн эргэн төлөлтийн судалгаа

Зээлийн төрөл	Зээлийн хүү /жилээр/	Зээл авсан огноо	Зээл төлж дуусах огноо	Төлсөн						2017.12.31-ээр		Хугацаа хэтэрсэн зээл
				Үндсэн төлбөр			Хүүгийн төлбөр			Балансын үлдэгдэл	Зээлийн гэрээний үлдэгдэл	
				2015	2016	2017	2015	2016	2017			
Дэлхийн банкны зээл МОН 3503	1%	2006.11.27	2036.04.01		-	36.5	4.0	23.3	7.0	858.8	676.0	(182.7)
Азийн хөгжлийн банкны зээл МОН-1847	3.25%	2006.04.19	2025.11.30		4.0	4.0	1.4	1.3	1.1	32.3	32.3	-
ДҮН				-	4.0	40.6	5.4	24.6	8.2	891.1	708.3	(182.7)

Компани 2016, 2017 онуудад ашигтай ажиллаж төлбөрийн чадвар сайн байхад гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй ба Зээлийн гэрээний 4.2-д зааснаар гэрээний үүргээ биелүүлж төлбөрөө төлөөгүй бол Сангийн яам тус компаний арилжааны банкин дахь данснаас үл маргах журмаар суутгах эрхтэй байгаа нь ирээдүйд компанийн болон орон нутгийн төсөвт хүндрэл учруулж болзошгүй тул цаашид дээрх хугацаа хэтэрсэн урт хугацаат зээлийг нэн даруй

төлж барагдуулан зээлийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг хангаж ажиллах зөвлөмжийг компанийн ТУЗ-д хүргүүлэв.

Гүйцэтгэх удирдлага нь 2016 онд аймгийн Засаг даргатай үр дүнгийн гэрээ байгуулаагүй, 2017 оны аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээг дүгнүүлж ажиллаагүй байна.

23. Компанийн гүйцэтгэх захирал нь аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ, “ЦДҮС” ТӨХК, “ДҮТ” ХХК-тай цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ байгуулан ажиллаж, цахилгаан эрчим хүч худалдан авах гэрээг улирал тутам дүгнэн актаар баталгаажуулж байгаа боловч аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээг дүгнүүлж биелэлтийг тооцуулаагүй байна.

ЭХЗХ-оос жил бүр тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн цахилгаан түгээх, хангах тусгай шаардлагыг баталж өгсний дагуу ЭХЗХ-ий өмнө үүрэг хүлээж жил бүр биелэлтийг тооцон дүгнүүлж ажилласан байна. Тухайлбал цахилгаан түгээх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын зорилтыг 2015, 2016, 2017 оны биелэлтийг “Сайн”, цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн зорилтын 2015 оны биелэлтийг “Дунд”, 2016, 2017 оны биелэлтийг Сайн” гэж дүгнэн ЭХЗХ-ноос 2018 оны “Тэргүүний байгууллага”-аар шалгаруулсан байна.

Компаний дүрмийн 9.2.5¹⁹-д зааснаар хагас жил тутам ажлын үр дүнг тайлагнаж дүгнүүлээгүй, жилийн эцэст ТУЗ-д ажлын тайланг тавьж жил бүр “Хангалттай” гэж дүгнүүлсэн байна.

Компанийн гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-тэй гэрээ байгуулаагүй байгаа нь компанийн дүрмийн 9.1, 9.2.2 дэх заалтыг зөрчсөн байна.

Гүйцэтгэх удирдлага нь тухайн жилүүдэд үйл ажиллагааг аюулгүйн ажиллагааны дүрмийн дагуу осолгүй явуулах, зорилтыг мөрдлөг болгон ажиллаж, 2017 оноос борлуулалтын албыг хэрэглэгчдэд үйлчлэх төвийн бүтцэд шилжүүлэн, шугмын алдагдлыг бууруулж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор сүүлийн үеийн техник технологийг нэвтрүүлснээр компанийн ашигт ажиллагаа 2016 оноос нэмэгдэж орон нутгийн хөрөнгийн үр ашиг гарч эхэлсэн байна.


Тухайлбал: 2015 оноос эхлэн аймгийн төвийн 6 кВ-ын ЦДАШ-ийн модон тулгуурыг төмөр бетон тулгуураар сольж шинэчилсэн, технологийн гол шийдэл

¹⁹ Хувь нийлүүлэгчдийн өмнө компанийн үйл ажиллагааг бүрэн хариуцаж, хагас бүтэн жилийн эцэст ажлын үр дүнг тайлагнан дүгнүүлэх

болсон реле хамгаалалтуудыг сүүлийн үеийн SEL хамгаалалтаар солих ажлыг ээлж дараатай авч хэрэгжүүлсэн, шугам сүлжээ, дэд өртөөний хуучирсан тоног төхөөрөмжүүдийг сольж шинэчилсэн, аймгийн төвд жилдээ 2-3 дэд станцыг барьж алдагдал багатай сүүлийн үеийн трансформаторыг туршиж суурилуулсан, улс орон нутгийн дэмжлэгтэйгээр 2017 онд Баянхонгор сумын 4, 5 дугаар багт 1100ш 2 тарифт тоолуур, 2017-2018 онд 3650ш 2 тарифт ухаалаг тоолуурыг нэвтрүүлж ажилласан байна.

Ухаалаг тоолуурыг нэвтрүүлснээр мэдээллийг программаас авах, залгах, таслах ажиллагааг хүний оролцгүй гүйцэтгэж цаг хугацаа хэмнэж үйл ажиллагааны зардлаа бууруулах, дэд станцын тоолууртай баланс хийх, алдагдал үнэн бодитой гарах, хүний буруутай үйл ажиллагаанаас гарах элдэв зөрчилгүй болох зэрэг сайн талтай байгаа бөгөөд хэрэглэгч ухаалаг тоолуураас хэрэглээгээ хянах гар утасны апплекейшн боловсруулж хэрэгжүүлж эхэлсэн байна. Иймд улсын хэмжээнд 2019 оныг “Ухаалаг эрчим хүч”-ний жил болгон зарласантай холбогдуулан ухаалаг тоолуурыг бүрэн нэвтрүүлэхээр ажиллаж эхэлсэн байна.

Хэрэглэгчдэд үйлчлэх төвийг 2017 онд байгуулснаар кассаар төлбөрөө тушаасан хэрэглэгчийн тоо 2017 онд өмнөх оноос 13440-өөр нэмэгдэж, борлуулалтын орлого 372.2 сая төгрөгөөр өссөн байна.



Аудитаар нийт 1073.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 14.9 сая төгрөгийн албан шаардлага өгч, зөрчлийг арилгах 1059.0 сая төгрөгийн зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэв.

Шалгагдагч байгууллагын санал:



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
“БАЯНХОНГОР ЭРЧИМ ХҮЧ”
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ
КОМПАНИ**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70442356

2019.06.27 № 196

танай _____ -ны № _____ т

Г _____ Г

Санал, тайлбар өгөх тухай

Г БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Б.Долминов
Санал, тайлбар
сүрьеэ үзсэн тайланг
туслах.
[Signature]

Тус байгууллагын 2015-2017 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитын тайлан, дүгнэлттэй танилцаад дараах санал, тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

Тайлбар №01-ийг
харна уу.

1. БОШХэмжээг бодит байдалд үндэслэн тухайн жилийн эхэнд компанийн тухай хууль, компанийн дүрэмд заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөл нь бүрэн эрхийн хэмжээнд компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө, ИЗТЗБАХэмжээ ажиллагсдын бүтэц орон тоо, цалингийн санг хэлэлцэн баталдаг. ТУЗөвлөлөөр батлагдсан үйл ажиллагааны төлөвлөгөөг Эрчим хүчний зохицуулах хороонд хүргүүлдэг. ЭХЗХороо нь тариф батлах журмын дагуу өмнөх оны гүйцэтгэлийг үндэслэн ирүүлсэн саналыг бууруулан баталж өгдөг нь бодит үйл ажиллагаанд хүрэлцэхгүй байдаг. Мөн ХАЦЭХ-ийг өмнөх жилүүдээс нэмэгдүүлэн худалдан авч байгаа нь борлуулалтын орлого нэмэгдэж үүнтэй холбоотой төлөвлөгдөөгүй зардал гарч байдаг. Манай компани нь Эрчим хүчний зохицуулах хороо, ТУЗ-өөр батлагдсан үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. Иймд аудитын илрүүлэлтээр гаргасан 427,8 сая.төгрөгийг зайлшгүй шаардлагатай гаргасан зардал гэж үзэж байгаа тул уг дүгнэлттэй санал нийлэхгүй байна.

Тайлбар №02-ийг
харна уу.

2. Үйл ажиллагааны бус орлогоос 110,0 сая төгрөгийг ойн арга хэмжээнд үр ашиггүй гэсэн дүгнэлтийн хувьд энэ зардлыг ТУЗ-ын хурлаар оруулан батлуулсан тогтоолын дагуу бүтээн байгуулалтын (байгууллагын гадна, дотор засвар, үйлчилгээ, тохижилт), ажлуудыг хийж гүйцэтгэснээр ажилтнуудын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах компанийн үзэмж, онцлог байдлыг харуулахаар зарцуулагдсан. Мөн тэгш ойн арга хэмжээний хүрээнд эрчим хүч үүсгэн

байгуулагдсанаас хойш дизель станцтай хүнд үеүдэд ажиллаж Баянхонгор аймгийг цахилгаан эрчим хүчээр хангаж байсан үе үеийн удирдах болон гүйцэтгэх ажил хийж байсан ахмад ажилчид, Баянхонгор аймгийг төвийн бүсийн эрчим хүчний системд холбосон компанийн удирдлага, аймгийн төвийн ЦШСүлжээний шинэчлэл, хөдөө сумдын цахилгаан эрчим хүчний эх үүсвэрийг хийж гүйцэтгэсэн компаниудын удирдлагуудыг урин оролцуулж хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан.Иймд Баянхонгор аймгийг цахилгаан эрчим хүчээр тасралтгүй найдвартай ханган ажиллаж байгаа байгууллагын хувьд тухайн зардлыг үр ашиггүй зарцуулсан гэж үзэхгүй байна.

Тайлбар №03-ийг
харна уу.

3. Харилцах дансны үлдэгдлийн хүүгийн орлогыг төлөвлөөгүй нь заавал төлөвлөгдөх тогтмол орлого биш юм.

Тайлбар №04-ийг
харна уу.

4. 2015-2017 онд үүссэн 14,9 сая төгрөгийн авлагыг барагдуулах албан шаардлагын дагуу арга хэмжээ авч,хуулийн байгууллагад хандаж ажиллаж байна.

Тайлбар №05-ийг
харна уу.

5. 2015-2017 онуудад олгогдсон техникийн нөхцөл авсан зарим Аж ахуй нэгжийн иргэдийн техникийн нөхцөл нь газрын маргаантай асуудлаас болж цуцлагдсан зарим нь баригдаагүй техникийн нөхцөл авсан боловч үйл ажиллагаа явуулаагүй эрчим хүчний яамнаас олгогдох техникийн нөхцөлийг манай компаниас авсан зэрэг төлөгдөх боломжгүй техникийн нөхцөлүүд байгаа ,төлөгдөх боломжтой техникийн нөхцөлийн төлбөрийг богино хугацаанд судалж төлүүлэх арга хэмжээ авч ажиллаж гүйцэтгэлийг хүргүүлэх саналтай байгаа тул акт тавих асуудлаа эргэн харна уу.

Тайлбар №06-г
харна уу.

6. Үйл ажиллагааны бус зардлаас баяр ёслол,ой тэмдэглэх, хандив тусламж дэмжлэг үзүүлж,тэмцээн уралдаанд хөрөнгө зарцуулахтай холбоотой гарсан зардлууд нь Эрчим хүчний салбарын хэмжээнд мөрдөгддөг хамтын гэрээний дагуу манай компанид жил бүр тодотгол хийж мөрдөгдөж байгаа хамтын гэрээний заалт болон ТУЗ-аас баталсан гүйцэтгэх захирлын сангаас гарган зарцуулагдаж байгаа. Уг зардлыг аймаг орон нутгийн удирдлага, хамтран ажилладаг харилцаа холбоо бүхий албан байгууллага аж ахуй нэгжүүдээс ирүүлсэн албан тоот хүсэлтийг үндэслэн гүйцэтгэх захирлын зөвлөлөөр хэлэлцүүлэн зарцуулдаг.

Тайлбар №07-г
харна уу.

7. ИЗТЗБАХ,хөрөнгө оруулалтын арга хэмжээнд тусгагдсан ажлыг нэр төрөл ангиллаар нь ТУЗ -ын хурлаар оруулан батлуулдаг. ТБОНӨХБАҮХАТухай хуулийг зөрчиж тендер зарлаагүй ажилласан тухайд танай байгууллагаас 2017 онд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар энэ талаар тендер зарлаж байх тухай зөвлөмж өгсний дагуу худалдан авах бараа материалыг тендерийн тухай хуулиар зохион байгуулж ажиллаж байгаа. Иймд 2017 оны зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа тул гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийг эргэн харна уу.

Тайлбар №08-ыг
харна уу.

8. Дэлхийн банкны МОН-3503 төслийн зээлийн 182,7 сая төгрөг гэрээний дагуу төлөөгүй шалтгаан нь 2016 он хүртэл компани алдагдалтай ажиллаж тариф хүрэлцэхгүйн улмаас зээлийг хугацаанд нь төлөх боломжгүй байсан. 2017, 2018, 2019 онуудад тарифт тусгаж өгссөнөөр графикийн дагуу төлөгдөж байгаа. Дэлхийн банкны зээл авсан бусад эрчим хүчний байгууллагууд нь уг зээлийг нэг ч удаа төлөөгүй байна. Манай байгууллага нь тарифт тусган төлж ажиллаж байна.

Дээрх санал, тайлбар өгсөн асуудлуудыг зөрчлийн дүнгээс хасуулах, дүгнэлтийг эргэн харж үзэхийг та бүхнээс хүсье.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Т. ОТГОНБААТАР

Саналд өгсөн тайлбар:

Тайлбарын дугаар	Саналыг хүлээн авсан эсэх	Тайлбар
Тайлбар №1	Үгүй	Тус компаний хувьд үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг ЭХЗХ олгож байгаа бөгөөд БОШХ-г мөн баталж өгч байгаа, аудитаар компанийн үйл ажиллагааны онцлог салбарын хууль тогтоомжуудад нийцүүлэн дүрмийг өөрчлөх гэсэн зөвлөмжийг аймгийн ИТХ-д өгч байгаа тул саналыг хүлээж авах боломжгүй.
Тайлбар №2	Үгүй	Компанийн 50 жилийн ойг угтаж хийж ажлын төлөвлөгөөнд батлагдсан 110.0 сая төгрөгөөс 53.6 сая төгрөгийг сургалтын полигон байгуулах, компанийн гаднах тохижилт, засварын ажил гэх мэт хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажилд зарцуулсан ч 45.6 сая төгрөгөөр ойн тэмдэглэхтэй холбоотой зочид хүлээн авах, ном, сонин, танилцуулга гаргах, баяр наадам, тэмцээн уралдаанд зарцуулсан байх тул саналыг хүлээж авах боломжгүй.
Тайлбар №3	Үгүй	Харилцах дансны үлдэгдэлд арилжааны банк өдөр тутамд хүү тооцдог тул орлогын боломжит эх үүсвэрүүдийг бүрэн тооцож төлөвлөх шаардлагатай тул тус саналыг хүлээж авах боломжгүй.
Тайлбар №4	Үгүй	Олон жил болсон насжилт өндөртэй авлагуудыг хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлж барагдуулж ажиллах шаардлагатай тул тус саналыг хүлээж авах боломжгүй.
Тайлбар №5	Тийм	Зарим техникийн нөхцлүүд цуцлагдсан, ЭХЯ-наас техникийн нөхцөл гаргуулж авсан гэсэн тайлбарыг өгч байгаа тул 2019.08.01-ий дотор төлүүлэх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.
Тайлбар №6	Үгүй	Төсвийн тухай хуулийн 25.10 дахь заалтыг зөрчиж бусад байгууллага, хувь хүнд хандив тусламж өгөхийг зогсоох зөвлөмж өгч байгаа тул тус саналыг хүлээж авах боломжгүй.
Тайлбар №7	Үгүй	ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу худалдан авалтыг хийж хэрэгжүүлэхдээ хуулийн 49.2-т заасан материалаас бүрдсэн тендерийн хавтаст хэргийг бүрдүүлж ажиллах шаардлагатай байгаа тул саналыг хүлээж авах боломжгүй.
Тайлбар №8	Үгүй	Зээлийн гэрээний 4.2-д зааснаар гэрээний үүргээ биелүүлж төлбөрөө төлөөгүй бол Сангийн яам тус компаний арилжааны банкин дахь данснаас үл маргах журмаар суутгах эрхтэй ба энэ нь ирээдүйд компанийн болон орон нутгийн төсөвт хүндрэл учруулж болзошгүй тул тус саналыг хүлээж авах боломжгүй.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. “Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК-ийн ТУЗ-ын бүрэлдэхүүнийг Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4-т заасны дагуу томилоогүй, компанийн дүрэмд заасан Хяналтын зөвлөлийг байгуулаагүй байна.
2. Жил бүр орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлж, тайлант онуудын ИЗТЗБАХ, хөрөнгө оруулалтын ажлуудыг үр дүнтэй хэрэгжүүлснээр компани 2016 онд 228.9 сая, 2017 онд 402.1 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.
3. ТУЗ нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2007 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 166 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдээс ногдол ашиг авах хуваарилах тухай” тогтоолыг хэрэгжүүлж, үйл ажиллагааны ашгийг хэрхэн хуваарилах саналыг аймгийн ИТХ-д хүргүүлж ажиллаагүй байна.
4. Эрчим хүчний тухай хууль болон Компанийн тухай хуулиар тус компанийн үйл ажиллагааны зардлыг батлах эрх бүхий субъект нь бүрэн зохицуулагдаагүй, хоорондоо зөрчилдөж байгаагаас ЭХЗХ болон ТУЗ-ын тогтоолууд зөрүүтэй батлагдаж байна.
5. Орон тооны авлагын мэргэжилтэн ажилласаар байхад цахилгаан эрчим хүчний 2015-2017 онд үүссэн 14.9 сая төгрөгийн авлагыг одоог болтол барагдуулаагүй байна.
6. Тэмцээн, уралдаан, хандив тусламж, баяр ёслол, ой тэмдэглэх зэрэг үр ашиг, үйлдвэрлэлийн үр өгөөж багатай зүйлд хөрөнгө ихээр зарцуулсан байна.
7. ИЗТЗБАХ, хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны бус орлогоор санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө төсвийг зардлын зүйл анги, хөрөнгийн нэр төрөл, тоо хэмжээгээр ангилж батлаагүй байна.
8. ИЗТЗБАХ, хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны бус орлогоор санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ ТБОНӨХБАҮХАТухай хуулийг мөрдөөгүй байна.
9. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихдаа аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 43 тоот тогтоолоор баталсан журмыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
10. Санхүүгийн үйл ажиллагаанд шинжилгээ хийж ажилласан боловч шинжилгээнд үндэслэн цаашид авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж ажиллаагүй байна.
11. Дэлхийн банкны МОН-3503 төслийн зээлээс 2012-2016 онуудад төлөх 182.7 сая төгрөгийг гэрээний дагуу төлөөгүй хугацаа хэтрүүлснээс ирээдүйд компанийн болон орон нутгийн төсөвт хүндрэл учруулж болзошгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурьдсан албан тушаалтнуудад зөвлөж байна.

Нэг. Аймгийн ИТХ-ын дарга Ц.Отгонбаяр танаа

1. “Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК-ийн үйл ажиллагааны онцлог, салбарын хууль тогтоомжуудтай нийцүүлэн компанийн дүрэмд өөрчлөлт оруулах.
2. Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4-т заасантай нийцүүлэн “Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК-ийн ТУЗ-ын бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох.
3. “Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК-ийн дүрмийн 10.2-д заасан хяналтын зөвлөлийг хувь нийлүүлэгчдийн хурлын тогтоолоор байгуулах.

Хоёр. Аймгийн Засаг дарга Г.Батжаргал танаа

1. “Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК-ийн Гүйцэтгэх захиралтай байгуулсан хамтран ажиллах гэрээг дүгнэж үр дүнг тооцож байх.
2. “Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК-ийн 2018-2019 оны бүтэц орон тоонд хяналт шалгалт хийх

Гурав. “Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК-ийн ТУЗ-ийн дарга С.Готов танаа

1. “Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК-ийн дүрмийн 10.3-д заасны хяналтын зөвлөлийн ажлын тайланг хэлэлцэж, үр дүнг тооцож ажиллах.
2. Компанийн үйл ажиллагааны ашгаас Дэлхийн банкны МОН-3503 төслийн зээлийн хугацаа хэтэрсэн 182.7 сая төгрөгийг барагдуулах талаар компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган, хугацаа хэтэрсэн зээлийн өргүй ажиллах.
3. Компанийн үйл ажиллагааны бус орлогоос гүйцэтгэх захирлын нөөц хөрөнгө хэмээн журамлагдаагүй зардал баталж өгдөг явдлыг зогсоох.

Дөрөв. “Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК-ийн гүйцэтгэх захирал Т.Отгонбаатар танаа

1. Зах зээлийн үнэ ханшийн судалгаанд үндэслэн хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бүрэн тодорхойлж, төлөвлөгөөнд тусгаж байх.
2. Төлөөлөн удирдах зөвлөлөөс шийдвэр гараагүй байхад хөрөнгө зарцуулдаг явдлыг зогсоох.
3. ИЗТЗБАХ, хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны бус орлогоор санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ ТБОНӨХБАҮХАТухай хуулийг мөрдөж ажиллах.
4. Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10 дахь заалтыг хэрэгжүүлж бусад байгууллага, хувь хүнд хандив тусламж өгөхийг зогсоох.
5. Тэмцээн, уралдаан, баяр ёслол, ой тэмдэглэх зэрэг арга хэмжээнд олгож байгаа зардлыг цаашид бууруулж орон нутгийн өмчийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж байх.

6. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс баталсан “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих” журмыг хэрэгжүүлж ажиллах.
7. Санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шинжилгээнд тулгуурлан цаашид авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг тооцож ажиллах.
8. Техникийн нөхцлийн дутуу төвлөрүүлсэн 5.9 сая төгрөгийн орлогын маргаантай асуудлыг судалж 2019 оны 09 дүгээр сарын 01-ний дотор шийдвэрлэх.

Зөвлөмжийн мөрөөр зохиосон ажил, түүний хэрэгжилт, үр дүнг 2019 оны 10 дугаар сарын 25-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.